



Ажил хайх нь

БИЕ ДААСАН БАЙДАЛ

ТАНИЛЦУУЛГА

ЭНЭ БҮЛЭГ НАДАД АЖИЛ ОЛОХОД ТУСЛАХ УУ?

Ажил олох нь амар хялбар зүйл биш боловч, бие даах чадвар хөгжүүлэх энэхүү бүлэг нь танд ажил олж мөн ажилдаа амжилт гаргах хамгийн шилдэг арга замын талаар суралцахад тань туслах болно. Та бүлгийн цугларалтаар тодорхой үйлдлүүд хийхээр амлаж, бүлгийнхэн тантай санал бодлоо хуваалцан, дэмжлэг туслалцаа үзүүлнэ. Энэ бүлгийн зорилго бол таныг зөвхөн бизнес хийхэд туслах төдийгүй, бас Их Эзэнд илүү дуулгавартай байх, илүү их итгэлээр үйлдэхэд мөн бидний сүнс-лэг болон материаллаг байдлын хувьд бие даах талаарх Түүний амласан адислалуудыг хүлээн авахад туслах явдал юм.

БИЕ ДААХ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ БҮЛЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Бие даах чадвар хөгжүүлэх бүлэг нь Сүмийн ихэнх анги, хичээл, сургалтаас өөр юм. Бүлэгт багш, удирдагч, дадлагажуулагч багш гэж байхгүй. Бүлгийн гишүүд хамтдаа суралцаж, нэг нэгнээ урамшуулан дэмждэг. Бид нэг нэгнийхээ өмнө өгсөн амлалтаа хэр биелүүлсэнд хариуцлага тооцож, асуудал гарвал хамтдаа авч хэлэлцэнэ.

БҮЛГИЙН ГИШҮҮД ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Цугларалтад бүлгийн гишүүд үйлдэл хийх амлалт өгнө. Бид зөвхөн суралцаад зогсохгүй, биднийг бие даахад туслах зүйлсийг хийж гүйцэтгэх болно. Бид амлалт өгч, нэг нэгэндээ уг амлалтаа биелүүлэхэд нь тусалж, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнана. Бүлгийн үйл ажиллагаа зөвлөл маягаар явагддаг учраас цугларалтдаа тогтмол, хоцролгүй оролцож байх нь чухал юм. Энэ дасгалын ном, Миний бие даах чадвартай болох арга зам болон Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил товхимлуудыг авчирсан байх ёстой. Бүлгийн цугларалт бүр ойролцоогоор хоёр цаг үргэлжилнэ. Өгсөн амлалтынхаа дагуу үйлдэхэд өдөрт нэгээс хоёр цаг шаардагдана.

ЗОХИЦУУЛАГЧ ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Зохицуулагч нь боловсрол олгоход, эсвэл зааж сургахад мэргэшсэн хүн биш юм. Тэд бүлгийг удирддаггүй буюу бүлэгт заадаггүй. Тэд зөвхөн материалыг яг бичигдсэний дагуу дагаж мөрдөхөд бүлгийнхэнд тусална. Ихэвчлэн бие даах чадварыг хөгжүүлэх мэргэжилтэн бүлгийн цугларалтыг зохицуулдаг ч, хэдэн долоо хоног өнгөрсний дараа, шаардлага гарвал бүлгийн гишүүдээс хэн нэгнийг зохицуулагчаар томилж болно. Нэмэлт мэдээллийг Удирдагчдын удирдамж болон srs.lds.org вэбсайт дээр байршуулсан дагалдах видео бичлэгүүдээс үзнэ үү.

СЕМИНАРЫН ГЭРЧИЛГЭЭ

Цугларалтдаа ирж, амлалт үүргээ биелүүлсэн бүлгийн гишүүд ХҮГ Бизнесийн Коллежоос бие даах чадварыг хөгжүүлэх ангийг дүүргэж, төгссөн гэрчилгээ авах шаардлагыг хангана. Тавигдах шаардлагыг "Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил" товхимлын 29-р хуудаснаас үзнэ үү.



"Хэрэв бид Их Эзэний арга замаар, нэг нэгэнтэйгээ жинхэнээсээ зөвлөлдвөл гэр бүл, тойрог эсвэл гадасны ямар ч асуудлыг шийдвэрлэх боломжтой."

M.РАССЭЛЛ БАЛЛАРД,
Counseling with Our Councils, засаж сайжруулсан хэвлэл (2012), 4

АГУУЛГА

1. Би хэрхэн өөртөө тохирох ажил олох вэ?	1
2. Би хэрхэн өөрийгөө бусдад онцгой сэтгэгдэл төрүүлэхүйц танилцуулах вэ?	21
3. Би хөдөлмөрийн “далд” зах зээл рүү хэрхэн орох вэ?	35
4. Би шууд сонгогдохын тулд ямар байх ёстой вэ?	53
5. Би хэрхэн ажил эрчимтэй хайх вэ?	77
6. Би ажлаа хэрхэн сайн гүйцэтгэж, үргэлжлүүлэн амжилт гаргах вэ?	95
7. Ажлын талаар яг одоо надад тулгарч буй хамгийн том бэрхшээл юу вэ?	113
8. Ажлын талаар яг одоо надад тулгарч буй хамгийн том бэрхшээл юу вэ?	121
9. Ажлын талаар яг одоо надад тулгарч буй хамгийн том бэрхшээл юу вэ?	129
10. Ажлын талаар яг одоо надад тулгарч буй хамгийн том бэрхшээл юу вэ?	137
11. Ажлын талаар яг одоо надад тулгарч буй хамгийн том бэрхшээл юу вэ?	145
12. Ажлын талаар яг одоо надад тулгарч буй хамгийн том бэрхшээл юу вэ?	153
Ажил хайх амжилтын хөтөч	163

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав

Юта муж, Солт Лэйк хот

© 2014 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Англи эхийн зөвшөөрөл: 8/13

Орчуулгын зөвшөөрөл: 8/13

My Job Search-ын орчуулга

Mongolian

12375 363



1

*Би хэрхэн өөртөө
тохирох ажил
олох вэ?*

Ажил хайх нь

ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

Цугларалт хийх өдөр:


- Хэрэв танд бүлгийн гишүүдийн холбоо барих мэдээлэл байгаа бол тэдэн рүү мессеж илгээ эсвэл утсаар ярь. Тэднээс цугларалтад ирэх эсэхийг асуу. Тэднийг 10 минутын өмнө ирж, ирцийн бүртгэл дээр гарын үсэг зурахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд:
 - Бүлгийн гишүүн бүрд зориулж, дасгалын дэвтэр болон *"Миний бие даах чадвартай болох арга зам"* товхимлын хувийг авч ир.
 - *"Миний бие даах чадвартай болох арга зам"* товхимлын таван хувийг илүү авч ир.
 - Боломжтой бол видео бичлэг үзүүлэхэд бэлд.
 - Ном эсвэл видео бичлэг байхгүй бол та тэдгээрийг онлайнаар srs.lds.org вэбсайтаас авч болно.

Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
 - Зохицуулагч нь цугларалтын үеэр зогсохгүй, мөн ширээний эхэнд суухгүй. Зохицуулагч анхаарлын төвд байх ёсгүй бөгөөд бүлгийн гишүүдийг нэг нэгэндээ анхаарал хандуулахад туслах ёстой.

Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд дотно хүлээн авч угт. Тэдний нэрийг чээжил.
- Бүртгэлийн хуудас дамжуулан явуулж, бүлгийн гишүүдээс өөрийн овог нэр, тойрог эсвэл салбар, мөн төрсөн огноогоо (*оныг оруулахгүй, сар, өдрөө бичнэ*) бичихийг хүс. Бүлгийн цугларалтын дараа srs.lds.org/report вэбсайт руу орж, зааврыг даган, бүлгийн бүх гишүүнийг бүртгэнэ.
 - Эхний цугларалтын дараа холбоо барих мэдээллийн жагсаалтыг гаргаад, дараагийн цугларалтаар бүлгийнхэнд тарааж өгнө.
- Бүлгийн цугларалтыг хуваарийн дагуу явуулахын тулд цаг бүртгэгч томил. Уг цаг бүртгэгчээс номонд заасны дагуу цаг хэмжигчийг тааруулахыг хүс.
 - Жишээлбэл, та "Цаг: Суралц хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул" гэсэн зааврыг харна. Цаг бүртгэгч нь хугацааг гар утас, бугуйн цаг эсвэл өөр бусад цаг хэмжих хэрэгсэл дээр тавих бөгөөд цаг дуусаж байгааг бүлгийнхэндээ мэдэгдэнэ. Үүний дараа бүлгийнхэн дараагийн хэсэг рүү орох, эсвэл хэлэлцүүлгээ дахин хэдэн минутаар сунгах эсэхээ шийднэ.



Цугларалт эхлэх үед:

- “Энэхүү бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт тавтай морилно уу” гэж хэл.
- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Дараах зүйлсийг хийх талаар бодож үз:
 - Энэ бол бие даах чадварын “Ажил хайх нь” бүлэг юм. Та нар бүгд ажилд орохоор эсвэл ажлаа сайжруулахаар энд ирсэн үү?
 - “Ажилд орох нь бие даах чадвартай болох зорилгын нэг хэсэг юм. Бид ажилд орсныхоо дараа үргэлжлүүлэн сайжрах болно. Та нар ажилд орсныхоо дараа ч гэсэн бүлгийн цугларалтад оролцох уу?
 - Бид 12 удаа цугларна. Цугларалт бүр ойролцоогоор 2 цаг үргэлжилнэ. Үүнээс гадна бид өдөр бүр боловсрол олоход, эсвэл мэргэжил эзэмшихэд тань туслах өгсөн амлалтаа биелүүлэхэд нэг юмуу хоёр цаг зарцуулах болно. Та энэ бүхнийг хийхэд цаг зав гаргах уу?”
- Нээлтийн залбирал хий (хүсвэл дуулал дуулж болно).
- Дараах зүйлсийг хийх талаар бодож үз:
 - “Цугларах болгондоо бид *“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил”* нэртэй товхимлын нэг сэдвээр эхэлж байх болно. Энэ товхимол нь бидэнд сүнслэг болон материаллаг тал дээр бие даах чадвартай болоход хөтлөх зарчим, үр чадвар, дадал хэвшлиүүдийн талаар суралцаж, тэдгээрийг дагаж амьдрахад туслах юм.
- **“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.**
- “Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын 2-р хуудсан дээрх Тэргүүн Зөвлөлийн захидлыг унш. Дараа нь уг товхимлын 1-р зарчмыг үзэж дуусгаад, энэ дасгалын номон дээр үргэлжлүүлэн ажилла.



Миний суурь:
Зарчим, үр чадвар,
дадал хэвшил
БИЕ ДААСАН БАЙДАЛ



СУРАЛЦ

БИД ЭНЭ БҮЛЭГТ ХАМРАГДСАНААРАА ЮУ ХИЙХ ВЭ?

Цаг: Суралц хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Унш: Бие даах чадвар хөгжүүлэх энэхүү бүлгийн зорилгыг ойлгохын тулд энэ дасгалын номны нүүрний ар талын хуудсыг нээж, танилцуулгыг унш.

Бид нэг нэгэндээ шинэ ажил эсвэл илүү сайн ажил олоход нь туслахын тулд энд ирсэн. Түүнчлэн бусдад илүү сайн хүрч үйлчлэхийн тулд бие даах чадвартай болох гэсэн илүү том зорилго бидэнд бий.

Дадлага хий: Бидний хамтдаа суралцах зарчмуудыг ашигладаг хүмүүс ажил олохдоо илүү хурдан байдаг. Энэ бол үр дүнтэй зүйл! Энэ дасгалын номны сүүлийн хуудсан дээрх Ажил хайх амжилтын хөтчийг ээлж ээлжээр унш.

Унш: Өдөр бүр бид ажил хайх байдлаа сайжруулах болно. Өнөөдрөөс эхлээд бид Ажил хайх амжилтын хөтөч дээрх зургаан асуултанд хариулахад анхаарлаа төвлөрүүлэх болно. Бид амлалт өгч, үйлдэж, мөн хийж гүйцэтгэсэн ажлаа бүлгийнхэндээ тайлагнана. Бид хамтдаа амжилт гаргана!

Бид суралцаж, *Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил* дээрх зарчмуудаар дадлага хийхийн тулд ажилд орсныхоо дараа ч гэсэн бүлгийн цугларалтад үргэлжлүүлэн ирэх болно. Бид бүлгийн гишүүдийг үргэлжлүүлэн дэмжиж, ажил хайхтай холбоотой бэрхшээл гарвал бүлгийнхнээсээ тусламж авч чадна.

Энэ 7 хоногийн асуулт ба үйлдлийг доор харуулав.

Унш: ЭНЭ 7 ХОНОГИЙН АСУУЛТ-Би хэрхэн өөртөө тохирох ажил олох вэ?

ЭНЭ 7 ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ- “Би 30 секундэд” мэдэгдлээ бэлтгэж, дадлага хийн, аль болох олон хүнтэй хуваалцана. Ажил эрчимтэй хайх талаар бодож үзнэ (санал болгосон үйл ажиллагааг хийнэ).

Цугларалтын үлдсэн хэсэг нь энэ асуултад хариулж, эдгээр үйлдлийг хийхэд бидэнд тусална.

Дадлага хий: Бүлгээрээ эхний үйлдлээ хийцгээе. Таван минутын дотор бүлэгтээ ямар нэр өгөхөө ярилцъя.

Бүлгийн нэрийг доор бич:



НАДАД ЯМАР ЯМАР УР ЧАДВАР БАЙДАГ ВЭ?

Ярилц: Та нар ажил хэрэгтэй байна гэж хүмүүст хэлэхээсээ санаа зовж байсан уу?

Унш: Бид санаа зовох ёсгүй! Бүх хүнд аль ч үед ажил хэрэгтэй болдог. Бид бүгдэд авьяас, туршлага бий. Үүнээс гадна бид бол Бурханы хүүхдүүд. Бид амжилтанд хүрч чадна! Бид маш сайн ажил хайж байгаа гэдгээ, мөн энэ ажлыг хийж чадна гэдгээ бүх хүнд хэлэх хэрэгтэй!

Дадлага хий: Гурав гурваараа нэг баг болж хуваагд. Өөд өөдөөсөө харж суугаад, дараах үйл ажиллагааг хий.

1. Та нарын нэг нь бусдадаа амжилт бүтээлийнхээ талаар ямар нэг зүйлийг хэл. Товч ярь! Жишээлбэл, Та “Би ажлаасаа сайн амжилтны шагнал авсан,” эсвэл “Би номлолд үйлчилсэн,” эсвэл “Би гурван хүүхэд өсгөсөн” гэх мэтээр хэлж болно.
2. Одоо энэ амжилтад хүрэхийн тулд ямар ямар ур чадвар хэрэгтэй байсныг нөгөө хоёр хүн танд аль болох хурдан хэлнэ. Дараа нь бүлгийн нөгөө хоёр хүн танд тэр ажлыг хийж гүйцэтгэхэд ямар ямар чадвар хэрэгтэй байсан талаар хурдхан хэлнэ. Хэрэв та “би номлолд үйлчилсэн” гэж хэлсэн бол багийн хүмүүс “Тэгвэл та зоригтой, сайн суралцагч, ажилсаг, удирдагч, нийгмийн амжилтан, зорилго тавьдаг, хүмүүстэй ажиллах чадвартай, багш, сайн төлөвлөгч бөгөөд хэцүү зүйлүүдийг хийх чадвартай” гэж хэлж болно.
3. Хүн болгон энэ маягаар давтаж хийнэ.

Ярилц: Бусад хүн таны авьяас, чадварын талаар ярих үед танд ямар санагдсан бэ?

Унш: Энэ хүснэгтэд ололт амжилтаа дугуйл, мөн нэмж бич. Ичих хэрэггүй. Дараа нь ур чадвар, зан чанаруудаа дугуйл, мөн нэмж бич. Тэнгэрлэг Эцэг таныг хэрхэн хардаг шиг өөрийгөө харахыг хичээгээрэй!

ОЛОЛТ АМЖИЛТ (Дугуйл, мөн нэмж бич)		УР ЧАДВАР, ЗАН ЧАНАР, ОЛОЛТ АМЖИЛТ (Дугуйл, мөн нэмж бич)	
Сүмийн дуудлага	_____	Шударга	Ажилсаг _____
Номлол	_____	Борлуулалт хийх чадвартай	Сайн сонсогч _____
Эцэг/эх болсон	_____	Найдвартай	Сайхан сэтгэлтэй _____
Ажлаасаа авсан шагнал	_____	Цэвэрлэх чадвартай	Механикийн ур чадвартай _____
Боловсрол	_____	Харьцааны чадвартай	Зорилго тавьдаг _____
Удирдлага	_____	Багшлах чадвартай	Авхаалжтай _____
Үйлчилгээ үзүүлсний шагнал	_____	Ухаалаг	Засвар үйлчилгээ хийх чадвартай _____
Хурал удирдаж байсан	_____	Барилга барих чадвартай	Тэвчээртэй _____
Ямар нэг зүйл зарж борлуулсан	_____	Бүтээлч	Сайн зан чанартай _____
Ямар нэг зүйл урласан	_____	Хурдан сурдаг	Баг бүрдүүлж чаддаг _____
Үг хэлсэн	_____	Төлөвлөдөг	Өөдрөг _____

БИ ӨӨРИЙНХӨӨ ТАЛААР БУСДАД ХЭРХЭН ХЭЛЭХ ВЭ?

Унш: Та нар олон чадвартай гэдгээ одоо мэдэж авлаа! Та сайн ажилтай болохын тулд чадвараа ашиглаж, хүмүүст хэрхэн тусалж чадахаа тэдэнд богино хугацаанд эрч хүчтэй танилцуулах хэрэгтэй. Бүлгийнхэнтэйгээ ээлжлэн “Софиагийн танилцуулга” хэсгийг унш.

СОФИАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Сайн байна уу? **1** Миний нэрийг Софиа Гонзалес гэдэг. **2** Би хувийн сургуулийн багш болохыг хүсэж байна. **3** Би таван жил заасан туршлагатай бөгөөд боловсролын диплом, сертификаттай. Миний сурагчид шалгалтанд өндөр оноо авдаг. **4** Би их хөгжилтэй багш, мөн сурагчид ч миний ангид хамгийн сайнаараа мэрийдэг.

1 Нэр **2** Зорилго **3** Мэргэшсэн байдал **4** Зан чанар

Дадлага хий: Одоо эдгээр дөрвөн хэсгээс бүрдсэн өөрийнхөө тухай танилцуулгыг хий. Үүнийг доорх шугаман дээр бич. Өөрт төрсөн бодлыг доор бич. 2-3 минут зарцуул. Дараах зүйлсийг багтаа:

1. Таны нэр _____
2. Таны хүсэж буй ажил (зорилго) _____
3. Энэ ажлыг сайн хийнэ гэсэн шалтгаан (мэргэшсэн байдал) _____

4. Энэ ажилд амжилт гаргахад тань туслах зан чанар эсвэл ур чадвар _____

Иймэрхүү танилцуулгыг “Би 30 секундэд” танилцуулга гэж нэрлэдэг. Нэг нэгээрээ босож зогсоод, “Би 30 секундэд” танилцуулгаа ашиглан, өөрсдийгөө танилцуул. Үүнийг 30 секундэд багтаа. Алга ташиж, нэг нэгнээ дэмжицгээе!

*“Би 30 секундэд”-ийн талаар зөвлөхөд:
Үүнийг товч байлга!
Хүмүүс хэдхэн секунд л сонсох болно.*

Унш: “Би 30 секундэд” танилцуулга нь өөрсдийгөө танилцуулах гайхалтай арга зам бөгөөд тодорхой тусмаа илүү үр дүнтэй байдаг. Бид ярилцаж буй хүндээ хандан, тодорхой зүйл нэмж асуух үед энэ нь илүү хүчтэй байдаг. Софиа уулзсан хүнээсээ шалтгаалан өөрийнхөө танилцуулга дээр өөр өөр асуулт нэмж тавих дадлага хийсэн байна:

Найз ба гэр бүлээс: Та ямар багшийг, эсвэл хувийн сургуультай хүнийг таньдаг вэ?

Нарийн бичгээс: Та намайг захирал хатагтай Гомезтой холбож өгч чадах уу?

Ажил олгогчоос: Миний туршлага танд хэрхэн тус болж чадах вэ?

Бид өөрсдийгөө аль болох олон хүнд танилцуулж, ажил хийх боломжтой байгаа гэдгээ мэдэгдэх ёстой.

Дадлага хий: “Би 30 секундэд” танилцуулгыг дахин бичихэд хэдэн минут зарцуул. Үүнийгээ илүү сайжруул. Тодорхой давуу тал, шинж чанараа нэмж бич. Ажил олгогчтой ярилцаж байхдаа тавьж болох асуулт нэмж бич.

Асуулт: _____

Дадлага хий: Бүлгээрээ дараах үйл ажиллагааг хий. Үүнд дээд тал нь таваас зургаан минут зарцуул.

1. Бүх хүн босоод, зайтай газар очиж зогс. Хүн бүр өөд өөдөөсөө харсан байх ёстой.
2. “Би 30 секундэд” танилцуулгаа хамтрагчдаа танилцуул.
3. Дараа нь нөгөө хүн “Би 30 секундэд” танилцуулгаа танд хэлнэ.
4. Нэг нэгэндээ энэ дүгнэх асуултыг хурдхан тавь:
 - Танилцуулга дөрвөн хэсэгтэй байсан уу? (нэр, зорилго, мэргэшсэн байдал, зан чанар)
 - Танилцуулга асуулгаар дууссан уу?
 - Уг хүн танилцуулгаа чин сэтгэлээсээ, өөртөө итгэлтэйгээр хэлсэн үү? Танилцуулга итгэл төрүүлэхүйц байсан уу?
 - Энэ хүн инээмсэглэсэн үү?
 - Та энэ хүнийг сонгож, түүнд ажил олгох байсан уу?
5. Дараа нь хамтрагчаа солиод, үүнийг давтаж хий. Дахин хий!
6. Үүнийг хүн бүр таван удаа хийх хүртэл аль болох хурдан хий.

1: Би хэрхэн өөртөө тохирох ажил олох вэ?

Унш: Одооноос эхлээд бид ажил хайж байгаа гэж хүмүүст хэлэхээсээ санаа зовохгүй байх болно. Бид амаа нээгээд, ажил хайж байгаа бөгөөд ямар ч ажилд тэнцэхүйц гэдгээ *хүн бүрд* хэлж чадна.

Бид дараагийн цугларалт болохоос өмнө уулзах бүх хүндээ “Би 30 секундэд” танилцуулгаа хэлэхэд бэлэн үү? Бид үүнийг хийх үү?

САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА: АЖИЛ ЭРЧИМТЭЙ ХАЙХ

(ҮҮНИЙГ ЦУГЛАРАЛТЫН ҮЕЭР ХИЙХГҮЙ.)

*Тав дахь цугларалт дээр бид ажил эрчимтэй хайх арга замын талаар суралцах болно. Гэсэн хэдий ч, **хэрэв та нар одоо илүү хурдан ажил хаймаар байгаа бол** өмнө нь энэ нэмэлт үйл ажиллагааг хийж болно. Та үүнийг ганцаараа эсвэл бусадтай хамт хийж болно.*

Бүр илүү хурдан амжилт олохыг хүсвэл та Эх сурвалж хэсгийн 15-20-р хуудсан дээрх Ажил эрчимтэй хайх хэсгийг судалж болно. Гэр бүлийнхэн, бүлгийн гишүүн эсвэл найзтайгаа ярилцаж, хамт суралц. Явж, үүнийг хий. Эх сурвалж ол, хүмүүстэй холбоо барь, мөн аль болох олон хүнтэй уулз. Үүнд өдөрт ойролцоогоор хоёроос дөрвөн цаг зарцуулагдах болно.

Ажил хайх нь өөрөө ажил юм! Гэхдээ хүмүүс энэ загварыг дагаснаар илүү хурдан ажил олдог.

Хэрэв та уг үйл ажиллагааг хийхээр сонгосон бол дараа нь эргэж ирээд, бүлгийнхэндээ тайлагна. Таны туршлага бүлгийн бусад гишүүнд тусална!

БИ САНХҮҮГЭЭ ХЭРХЭН УХААЛАГ ЗОХИЦУУЛАХ ВЭ?

- Унш:** Бие даахын нэг хэсэг бол олсон орлогоосоо бага зарцуулж, хадгаламжиндаа мөнгөтэй байх явдал юм. Хадгаламж нь төлөвлөгдөөгүй зардлууд гарахад, эсвэл бидний орлого тооцоолж байснаас бага болох үед өөрийн болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангахад туслах юм. Бид энэ бүлгийн гишүүний хувьд долоо хоног бүр, ганц хоёр төгрөг байсан ч гэсэн хадгаламжиндаа хийж байх амлалт өгч байна.
- Ярилц:** Зарим улс оронд банкинд мөнгөө хадгалуулах нь зөв шийдвэр байдаг. Харин мөнгөний ханшны уналт ихтэй, эсвэл банкны систем нь тогтворгүй зарим улс оронд банкинд мөнгөө хадгалуулах нь зөв шийдвэр байж чаддаггүй. Танай улс оронд банкны хадгаламжийн нөхцөл хэр сайн бэ? Аль банкны хадгаламжийн хүү хамгийн өндөр вэ?
- Унш:** Бие даахын өөр нэг чухал хэсэг бол хувийн өр зээлгүй байх явдал юм. Бид төлж чадахаасаа илүү их мөнгө зарцуулах үед хувийн зээлийг ашигладаг. Бошиглогчид бидэнд хувьдаа зээл авахаас зайлсхийхийг, мөн илүү их бие дааж эхлэхдээ зээлээ багасган, улмаар төлж барагдуулахыг (бизнесийн зээл авах нь зарим тохиолдолд ухаалаг ч) зөвлөсөн байдаг.
- Эмчилгээний гэнэтийн зардлууд нь ихэнхдээ санхүүгийн хувьд томоохон дарамт үүсгэдэг. Даатгал, засгийн газрын эрүүл мэндийн хөтөлбөрүүд ихэнхдээ биднийг эдгээр дарамтад орохоос сэргийлдэг. Даатгалд эсвэл засгийн газрын эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд хамрагдах нь бидний бие даах чадвараа хөгжүүлэх арга замын чухал хэсэг байж болно.
- Ярилц:** Зарим төрлийн даатгалд (эрүүл мэндийн болон амь насны даатгал гэх мэт) хамрагдах боломж их байдаг бөгөөд тэдгээр нь бусад төрлийн даатгалаас илүү ашигтай байдаг. Зарим даатгалын үйлчилгээ үзүүлэгч сайн байхад, зарим нь шударга бус байх тохиолдол бий. Танай улсад ямар даатгалын байгууллага хамгийн сайн нь вэ?

ИХ ЭЗЭН ЯАГААД БИДНИЙГ БИЕ ДААХ ЧАДВАРТАЙ БАЙГААСАЙ ХЭМЭЭН ХҮСДЭГ ВЭ?

Ярилц: Яагаад Их Эзэн биднийг бие даасан байлгахыг хүсдэг вэ?

Унш: Баруун гар талд байгаа эшлэлийг унш.

Ярилц: Ахлагч Кристоффэрсоны хэлснээр, бидний ажилд орох гэсэн хичээл зүтгэл хэрхэн “ариун зорилгод” үйлчилж байгаа вэ?

Унш: Биднийг бие даахад туслах хүч чадал Аврагчид бий. Тэрээр “Учир нь болгоогтун, би бол Бурхан, мөн би бол гайхамшгуудын Бурхан” (2 Нифай 37-23) хэмээн хэлсэн байдаг. Бид ажил хөдөлмөртөө амжилт гаргахсан гэсэн хичээл зүтгэлээ бие даах гэсэн ариун зорилгод зориулах, эсвэл өргөл болгох аваас Их Эзэн биднийг сүнслэг өдөөлтөөр дамжуулан удирдах болно. Бид Түүнээс ирэх сүнслэг өдөөлтийг сонсон, дагаснаараа итгэлээ харуулах үед Их Эзэн гайхамшгуудыг үйлдэж, бидний хийж чадахаас ч их зүйлийг бидэнд өгөх болно.

“Өргөл болгох гэдэг нь ямар нэгэн ариун болох зүйлийг ариун зорилгод зориулагдсан хэмээн хуримтлуулах, эсвэл өргөл болгох гэсэн утгатай юм.”

**Д.ТОДД
КРИСТОФФЭРСОН,
“Өргөл болгосон амьдралын тухай бодол эргэцүүлэл,” Ensign эсвэл
2010 оны 10-р сарын
Ерөнхий чуулган, 17**



ТУНГААН БОД

БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Цаг: Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр нэг судар хуваалцахыг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

Ярилц: Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

“Та нар түүгээр дэгжиг болохын тулд өөрсдийн талбай дахь ургацынхаа төлөө түүнээс гуй. Тэдгээр нь өсөж үржихийн тулд төлөө гуй, талбай дахь сүргийнхээ.”

АЛМА 34:24-25



АМЛАЛТ ӨГ

БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

Цаг: Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Унш: Бид долоо хоног бүр “хамтрагчаа” сонгоно. Энэ хамтрагч нь өгсөн амлалтаа биелүүлэхэд бидэнд туслах тус бүлгийн гишүүн байна. Хамтрагчид нь долоо хоногийн турш нэг нэгэнтэйгээ холбогдож, хийж гүйцэтгэсэн ажлаа бие биендээ тайлагнана. Ерөнхийдөө, хамтрагч нь нэг хүйсийнх байх бөгөөд гэр бүлийн гишүүн бус хүн байна.

Дадлага хий: Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

Хамтрагчийн нэр

Холбоо барих мэдээлэл

Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.

МИНИЙ АМЛАЛТУУД

Би “Би 30 секундэд” танилцуулгаа наад зах нь 20 хүнд хэлнэ.

Зорилгоо дугуйл: 20 30 40

Би өнөөдрийн “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

Миний гарын үсэг

Хамтрагчийн гарын үсэг

БИ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

Үз: “Үйлдэл ба амлалт” (Видео бичлэг байхгүй бол 14-р хуудсыг унш.)

Унш: Бид амлалтаа тайлагнаж байвал, тэдгээрийг биелүүлэх магадлал өндөр байдаг. Баруун гар талд байгаа эшлэлийг унш.

Дадлага хий: Дараагийн цугларалтын өмнө хийж гүйцэтгэсэн ажлаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх зайд “Тийм”, “Үгүй” гэж, эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Би “Би 30 секундэд” танилцуулгаа наад зах нь 20 хүнд хэлсэн (Тоог бич)	“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгалам-жиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

Унш: Түүнчлэн “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлынхоо арын хуудсан дээр зарлагаа тэмдэглээрэй.

Бидний дараагийн цугларалтын үеэр зохицуулагч самбар дээр амлалтын хүснэгт зурна (дээрхтэй адил). Бид цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, хүснэгт дээр өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлыг бичнэ.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” дээрх сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. Зохицуулагч юу хийдэг талаар олж мэдэхийн тулд тэднээс энэ дасгалын номны нүүр хавтасны арын хуудаснаас уншихыг хүс. Тэд өнөөдөр зохицуулагчийн хийж гүйцэтгэсэнтэй адил зүйлийг хийхэд туслах ёстой.

- Сүнснийг урь. Бүлгийн гишүүдийг Сүнснийг эрэлхийлэхэд урь.
- Ашиглаж буй материалдаа бүрэн найд. Бүү нэм. Зөвхөн хий гэсэн зүйлийг л хий.
- Цагаа зохицуул.
- Эрч хүчтэй, хөгжилтэй бай!

Хэн нэгнээс хаалтын залбирал хийхийг хүс.



“Гүйцэтгэлийг хэмжвэл, гүйцэтгэл сайжирдаг. Гүйцэтгэлийг хэмжиж, тайлагнаж байвал сайжрах хурд нэмэгддэг.”

(ТОМАС С.МОНСОН, Conference Report, 1970 оны 10-р сар, 107)

Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа srsfeedback@ldschurch.org хаягаар илгээнэ үү.

Зохицуулагчийн анхааралд:

Бүлгийн бүх гишүүнийг srs.lds.org/report вэбсайт дээр бүртгүүл.

Түүнчлэн бүлгийн гишүүдийн холбоо барих мэдээллийг хувилж олшруулахаа битгий мартаарай.

Эх сурвалж

ҮЙЛДЭЛ БА АМЛАЛТ

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

БҮЛГИЙН 1 ДЭХ ГИШҮҮН: Бид амлалт өгч, түүнийгээ биелүүлэх ёстой гэдэгт итгэдэг. Манай бие даах чадвар хөгжүүлэх бүлгүүдэд бидний хийж буй бүх зүйл амлалт өгөх, тайлагнахад тулгуурладаг.

БҮЛГИЙН 2 ДАХЬ ГИШҮҮН: Бид бүлгийн цугларалтын төгсгөлд, долоо хоногт өөрсдийн хийх зүйлийн талаар хэлэлцэж, амлалт өгснөө батлахаар гарын үсгээ зурдаг. Түүнчлэн бид “хамтрагчаа” сонгодог. Хамтрагч маань бидний дасгалын дэвтэр дээр гарын үсэг зурж, дэмжин туслах үүрэг хүлээдэг. Цугларалт хооронд, өдөр бүр бид хамтрагчтайгаа холбогдож, хийсэн ажлаа тайлагнаж, шаардлагатай үед тусламж авдаг.

БҮЛГИЙН 3 ДАХЬ ГИШҮҮН: Цугларалт хооронд, бид хийсэн ажлаа дасгалынхаа номон дээр тэмдэглэж, дасгалын хуудас эсвэл өөр маягтууд гээд бидэнд тарааж өгсөн хэрэгслүүдийг ашигладаг. Нэмэлт тусламж хэрэгтэй бол бид гэр бүл, найз нөхөд эсвэл зохицуулагчдаа ханддаг.

БҮЛГИЙН 4 ДЭХ ГИШҮҮН: Дараагийн цугларалт эхлэхэд бид ирж, амлалтаа хэрхэн биелүүлснээ тайлагнана. Энэ нь хүн бүрийн хувьд таатай, хүчирхэг туршлага байх ёстой. Бүлгийн бүх гишүүнийг тайлагнах үед тэд хэрхэн танд

амлалт өгч, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнахад тусалсан талаар бод.

БҮЛГИЙН 1 ДЭХ ГИШҮҮН: Эхлээд би өөрийн амлалтын талаар тайлагнахад надад “Ямар сонин юм бэ?” Манай бүлгийн гишүүдэд миний юу хийж байгаа нь яагаад чухал гэж? хэмээн бодогдсон. Харин дараа нь би тэд үнэхээр миний төлөө санаа тавьдаг болохыг олж мэдсэн. Энэ нь надад их тусалсан шүү.

БҮЛГИЙН 2 ДАХЬ ГИШҮҮН: Би бүлгийнхээ нэр төрийг унагаахыг хүсээгүй. Тийм болохоор би өгсөн амлалтаа биелүүлэхийн тулд их хичээл зүтгэл гаргасан. Би өөр арга замаар амжилт гаргахгүй байсан байх. Цугларалт болгоноор тайлагнах нь надад юу чухал болохыг мэдэж авахад тусалсан.

БҮЛГИЙН 3 ДАХЬ ГИШҮҮН: Бие даах чадвартай болох арга зам нь их чухал зүйл болохоор би бодохоос ч айж байсан. Гэвч бүлгийн цугларалтууд нь надад үүнийг жижиг жижиг алхмуудад хувааж өгч тусалсан юм. Би алхам болгоноо бүлгийнхэндээ тайлагнадаг байсан. Түүний дараа харин би бодит ахиц гаргаж эхэлсэн. Миний бодлоор би шинэ дадал хэвилийг хөгжүүлснийхээ үр дүнд энэхүү амжилтад хүрсэн байх.

13-р хуудас руу буцаж оч

АЖИЛ ЭРЧИМТЭЙ ХАЙХ ТАЛААР БОДОЖ ҮЗЭЭРЭЙ (САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА)

Ажил хайлтаа хурдасгахын тулд эдгээр материалыг судалж мөн ашигла! Та гэр бүлийнхэн, бүлгийн гишүүн эсвэл нэг найз, зөвлөгчтэйгөө хамт үүн дээр ажиллаж болно.

Үз: “Рафаэл: 6 өдрийн дотор ажилд оров” (Видео бичлэгийг srs.lids.org-ээс үзнэ үү.)

Ярилц: Рафаэлийг ажил амжилттай хайж олоход юу тусалсан бэ?

Унш: Ажил эрчимтэй хайх нь өдөр тутам ажил хайх үр дүнтэй стратеги юм. Зарим газарт энэ арга нь ажил олох хугацааг 200 хоногоос 20 хоног хүртэл багасгаж чадсан! Энэ нь маш их хүч чармайлт шаарддаг. Энэ нь өдөр тутам хийх гурван үйл ажиллагааг багтаадаг:

- 15 шинэ эх сурвалж тодорхойл.
- 10 хүнтэй холбоо барь.
- 2 хүнтэй нүүр тулсан уулзалт эсвэл ярилцлага хий.

Үз: “Өдөр тутам ажил хайх нь: Эх сурвалж” (Видео бичлэгийг srs.lids.org-оос үз эсвэл дараахыг унш.)

Бид судруудаар дамжуулан, “хүмүүс сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж, мөн чөлөөт хүсэл зоригоороо олон зүйлийг хийж, Учир нь хүч тэдэнд буй, үүгээр тэд өөрсдийнхөө төлөө сонгогчид юм” гэдгийг мэдэж авдаг. Энэ зарлиг нь нэг амлалтыг дагуулдаг: “Мөн хүмүүс сайныг үйлдэхийн хэрээр тэд яавч шагналаа алдах учиргүй” (С ба Г 58:27–28).

Үр дүнтэй ажил хайдаг хүмүүс “хүч тэдэнд буй” бөгөөд тэд “санаа сэтгэлээ бүрэн зориулах” үед Бурхан тэдэнд түсэлнэ гэдгийг ойлгодог. Тухайлбал, бид гурван хэсгээс бүрдсэн ажил хайх шалгарсан нэг стратегийг ярилцах болно. Үүнийг ажил эрчимтэй хайх гэж нэрлэдэг.

Нэгдүгээрт, ажил амжилттай хайдаг хүмүүс өдөр бүр 15 шинэ эх сурвалж тодорхойлдог. Хоёрдугаарт, тэд өдөр бүр 10 хүнтэй холбоо барьдаг. Гуравдугаарт, тэд өдөр бүр наад зах нь 2 нүүр тулсан уулзалт эсвэл ярилцлага хийдэг.

Ажил эрчимтэй хайхад эхэндээ маш хэцүү мэт санагдаж болно. Гэхдээ бид хэсэг бүрийг ярилцсанаар энэ нь боломжтой бөгөөд амжилттай гэдгийг та нар харах болно.

Эх сурвалжийг судалж эхэлье. Эх сурвалж гэж юу вэ? Эх сурвалж гэдэг нь хүн, газар, эсвэл ажил хайгчийг боломж руу хөтөлж чадах ямар нэг зүйл юм.

Хүмүүс гэдэгт найзууд ба гэр бүл, Сүмийн гишүүд ба удирдагч, ажил олгогчид эсвэл хамт ажиллагч, сургуулийн багш болон ажил мэргэжлийн зөвлөх, дэлгүүрт буй хүмүүс гээд хэрэгцээтэй ажлын мэдээлэл, эх сурвалжаар таныг хангаж чадах хүмүүс юм.

үргэлжлэл бий

1: Би хэрхэн өөртөө тохирох ажил олох вэ?

Газар гэдэгт худалдааны танхим, орон нутгийн ажил эрхлэлтийн албад болон иргэний эсвэл мэргэжлийн холбоод орно. Эдгээр нь бүгд таныг хэрэгтэй мэдээллээр хангадаг.

Таны ажил хайх явцыг сайжруулах зүйл нь бизнес ба утасны лавлах, компанийн вэб хуудас, интернэт, худалдааны мэдээ, сэтгүүл, сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг багтаадаг.

Өдөр бүр эдгээрээс наад зах нь 15 зүйлийг жагсаан бич.

Дадлага хий: Цаас аваад, гурван багана болгон зурж хуваа. Багануудын дээр “Эх сурвалж,” “Танилын хэлхээ холбоо” ба “Уулзалт” гэж бич. Эхний багананд аль болох олон эх сурвалж жагсаан бичих замаар энэ цаасыг яг одоо бөглөж эхэл. Эдгээр нь танд тустай мэдээлэл бүхий хүмүүс ба газар, зүйлүүд юм! Зарим нэг жишээг доор өгөв: Та бусад баганыг дараа бөглөнө.

ЭХ СУРВАЛЖ (жагсаалт гарга)	ТАНИЛЫН ХЭЛХЭЭ ХОЛБОО ТОГТООХ (утас, э-мэйл)	УУЛЗАЛТ (нүүр тулсан)
Интернэт сайтууд	Чуулгын эсвэл Халамжийн Нийгэмлэгийн гишүүд	Боломжит ажил олгогчид
Сониууд	Тантай хамт ажилладаг байсан хүмүүс	Гэрийн багш нар
Ажилд зуучлах үйлчилгээ	Багш нар	Сүмийн гишүүд
Бие даах чадвар хөгжүүлэх төв	Дэлгүүрт тааралдсан хүмүүс	

үргэлжлэл бий

Үз: “Өдөр тутам ажил хайх нь: Танилууд” (Видео бичлэгийг srs.lds.org-оос үз эсвэл дараахыг унш.)

Одоо хэрхэн холбоо тогтоох талаар ярилцъя. Холбоо тогтоох гэдэг нь товч намтраа явуулах эсвэл өргөдөл бөглөх төдий зүйл биш юм. Та тодорхойлсон бүх эх сурвалжаасаа ажил эрхлэлттэй холбоотой 10 хүнийг тодорхойл.

Танилын хэлхээ холбоо гэдэг нь ажилд өргөдөл бөглөх, хэн нэгэнд товч намтраа эсвэл талархлын зурвас илгээх, мөн найз, гэр бүл, Сүмийн гишүүдэд ажил хайж байгаагаа хэлэх эсвэл мессеж, э-мэйл бичих гэх мэт ажил эрхлэлттэй холбоотойгоор таны хүмүүстэй үүсгэсэн харилцаа холбоо юм. Та түүнчлэн өөр бусад сүлжээний танилууд ба боломжит ажил олгогчтой уулзсан байж болно. Хүмүүстэй харилцах өөр өөр боломжуудыг эрж хай, мөн ажил хайж байгаа гэдгээ тэдэнд хэл. Ихэнх хүн таныг таньдаг хүмүүстэйгээ дуртайяа танилцуулах болно. Эдгээр харилцаа холбоо нь ярилцлага руу, ярилцлага нь ажил руу хөтлөх болно!

Дадлага хий: Одоо өөрт байгаа цаасаа ашиглан дараагийн цугларалтаас өмнө холбоо тогтоох боломжтой аль болох олон хүний нэрийг жагсаан бич. Санаа зовох хэрэггүй гэдгийг сана. Өдөрт 10 хүнтэй холбоо тогтоох арга замыг хайж ол!

Үз: “Өдөр тутам ажил хайх нь: Уулзалтууд” (Видео бичлэгийг srs.lds.org-оос үз эсвэл дараахыг унш.)

Эцэст нь хэлэхэд, үр дүнтэй ажил хайдаг хүмүүс өдөр бүр наад зах нь хоёр хүнтэй нүүр тулж уулзахын үнэ цэнийг ойлгосон байдаг. Энэ нь өдөр бүр таны хийх хамгийн чухал зүйл байж болох юм. Яагаад? Нүүр тулсан уулзалт, ярилцлагууд нь шүү сайн харилцаа, ойлголтыг бий болгодог. Хүмүүс ихэвчлэн биеийн хэлэмж ба нүүрний хувирлаараа “ярьдаг.” Эдгээр үгийн бус харилцааг э-мэйлээр юм уу утсаар илэрхийлэх боломжгүй юм. Биечлэн уулзах үед хүмүүс таныг ямар гайхалтай болохыг харж мөн мэдэрч чадна!

Түүнчлэн нүүр тулсан уулзалтууд нь ажиллаж магадгүй орчноо харах боломжийг танд олгодог. Та хүмүүсийн хэрхэн харилцаж байгааг, хэр нөхөрсөг эсвэл аз жаргалтай байгааг болон тухайн байгууллагын амжилт, ямар хэрэгцээ эсвэл боломжууд байгааг мөн тэдгээр хэрэгцээг та хэрхэн хангаж чадах зэрэг зүйлсийг анзаарч чадна. Ямар ч төрлийн ярилцлага сайхан боломж байдаг!

үргэлжлэл бий

1: Би хэрхэн өөртөө тохирох ажил олох вэ?

Нүүр тулсан уулзалт бүрийг боломжит ажил олгогчтой хийх шаардлагагүй. Та мөн найзууд, гэр бүл, мөн найзын найз, нарийн бичиг, багш, зөвлөхүүдтэй, эсвэл таны хийхийг хүсч буй ажлыг хийдэг хүмүүстэй уулзаж болно. Зүгээр л хүмүүстэй уулз! Тэдэнд “Би 30 секундэд” танилцуулгаа хэлж, мөн төгсгөлийн асуултаа ашиглаад ажлын боломж ба уулзах өөр хүмүүсийг асуу. Үүнийг үргэлжлүүлэн хийж бай. Эрхэмлэдэг зүйлүүдээ ойлгуулж, тусламж, зөвлөгөө хүсэж байгаарай. Агуу зүйлүүд тохиолдох болно! Үүнийг ажил эрчимтэй хайх гэж нэрлэдэг! Та өдөр бүр 15 эх сурвалжийг тодорхойлж, 10 хүнтэй холбоо тогтоовол нүүр тулсан 2 ярилцлага хийх нь амархан байх болно. Энэ нь ажил хайх явцыг тань хэрхэн хурдасгахыг хараад та гайтах болно. Үүнийг агуу итгэлээр хий, ингэснээр таны төсөөлж ч байгаагүй үүд хаалга нээгдэх болно.

Дадлага хий: Одоо өөрт байгаа цаасаа ашиглан дараагийн цугларалтаас өмнө холбоо тогтоох боломжтой аль болох олон хүний нэрийг жагсаан бич. Тэдэнтэй хэзээ мөн хэрхэн уулзахаа бод. Уулзалт бүр дээр “Би 30 секундэд” танилцуулгаа ашиглахаа битгий мартаарай.

Үз: “Өдөр бүр ажил хайх нь: Бүгдийг хамтад нь ашиглах нь” (Видео бичлэгийг srs.lds.org-оос үз эсвэл дараахыг унш.)

Ажил эрчимтэй хайхын гурван хэсэг нь салангид үйл ажиллагаанууд биш юм. Та хийж үзээд, эх сурвалж хаа сайгүй байгааг харах болно. Өдөр бүрийг жагсаалтдаа ямар нэгэн зүйл нэмж бичих замаар эхлүүл. Та үүнийг хийснээрээ хүмүүстэй холбоо барих арга замуудыг бодож, мөн холбоо тогтоосноор аяндаа уулзалт руу хөтөлдөг.

Бие даах чадвар хөгжүүлэх энэхүү бүлэг бол эх сурвалж, танил тал, уулзалтуудын гайхалтай эх сурвалж юм. Сүмийн гишүүн, хөриүүд эсвэл хамтран ажиллагчид ч гэсэн үүнтэй адил. Холбоо тогтоох бүрдээ эх сурвалжуудаа нэмж бичиж бай. Нүүр тулсан уулзалт хийх үедээ өөр хүний холбоо барих мэдээллийг асуу. Уулзсан хүн бүртэйгээ ярилцлаганд дахин оролцохыг хүс.

“Би 30 секундэд” танилцуулгаа ашигла. Ажил эрчимтэй хайх нь боломжтой зүйл бөгөөд хийгээд эхлэхэд л сонирхолтой санагдах болно. Тиймээс зүгээр битгий суу. Хүн бүртэй ярилц. Ариун Сүнсний удирдамжийг байнга эрэлхийлж, зохистой амьдар. Сайн тэмдэглэл хөтлөөд, үүнийхээ дагуу үйлд. Таныг үйлдэх үед Их Эзэн замаа олоход тань тусална.

Дадлага хий: Одоо цаасаа хар. Та эхлээд юу хийх вэ? Эх сурвалж олж, холбоо тогтоон, өдөр бүр нүүр тулсан уулзалт хийх төлөвлөгөө гарга. Үүнийг хэзээ хийхээ шийдээд, гэр бүлийнхнээсээ эсвэл хамтрагчаасаа тусламж хүс.

Гаргаж буй ахицаа дараагийн хуудсан дээрх хүснэгтэд тэмдэглэж хэмж. Холбоо барих хүмүүсээ 20-р хуудсан дээрх Эргэж холбоо барих гэсэн маяганд бүртгэ. Нэлээн хэдэн хувийг бэлтгэ.

АЖИЛ ЭРЧИМТЭЙ ХАЙХ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Үйлдэл бүрийг хийж дуусган, тэмдэглэл бичсэнийхээ дараа дөрвөлжин нүдийг чагтал.

1 ДЭХ ӨДӨР

Эх сурвалж: Нийт өдрийн тоо _____

Холбоо тогтоосон: Нийт өдрийн тоо _____

Уулзалт: Нийт өдрийн тоо _____

Тэмдэглэл:

2 ДАХЬ ӨДӨР

Эх сурвалж: Нийт өдрийн тоо _____

Холбоо тогтоосон: Нийт өдрийн тоо _____

Уулзалт: Нийт өдрийн тоо _____

Тэмдэглэл:

3 ДАХЬ ӨДӨР

Эх сурвалж: Нийт өдрийн тоо _____

Холбоо тогтоосон: Нийт өдрийн тоо _____

Уулзалт: Нийт өдрийн тоо _____

Тэмдэглэл:

4 ДЭХ ӨДӨР

Эх сурвалж: Нийт өдрийн тоо _____

Холбоо тогтоосон: Нийт өдрийн тоо _____

Уулзалт: Нийт өдрийн тоо _____

Тэмдэглэл:

5 ДАХЬ ӨДӨР

Эх сурвалж: Нийт өдрийн тоо _____

Холбоо тогтоосон: Нийт өдрийн тоо _____

Уулзалт: Нийт өдрийн тоо _____

Тэмдэглэл:

ХОЛБОО БАРИХ ХҮМҮҮСИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

ХОЛБОО БАРИХ

Хувь хүн эсвэл байгууллага: _____

Утас: _____ Хаяг: _____

Э-мэйл хаяг: _____ Намайг танилцуулсан хүн: _____

Би энэ хүнтэй холбоо тогтоосон Тийм Үгүй Огноо: _____

ЯРИЛЦСАН АСУУДАЛ:

1. _____

2. _____

3. _____

ДАРАА ХИЙХ ЗҮЙЛС:

1. _____ Дуусгасан байх (огноо): _____

2. _____ Дуусгасан байх (огноо): _____

3. _____ Дуусгасан байх (огноо): _____

ШИНЭ ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ:

1. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

2. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

ХОЛБОО БАРИХ

Хувь хүн эсвэл байгууллага: _____

Утас: _____ Хаяг: _____

Э-мэйл хаяг: _____ Намайг танилцуулсан хүн: _____

Би энэ хүнтэй холбоо тогтоосон Тийм Үгүй Огноо: _____

ЯРИЛЦСАН АСУУДАЛ:

1. _____

2. _____

3. _____

ДАРАА ХИЙХ ЗҮЙЛС:

1. _____ Дуусгасан байх (огноо): _____

2. _____ Дуусгасан байх (огноо): _____

3. _____ Дуусгасан байх (огноо): _____

ШИНЭ ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ:

1. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

2. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____



2

*Би хэрхэн өөрийгөө
бусдад онцгой
сэтгэгдэл төрүүлэхүйц
танилцуулах вэ?*

Ажил хайх нь

ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд. Ном эсвэл видео бичлэгүүд байхгүй бол та тэдгээрийг онлайнаар srs.lds.org вэбсайтаас авч болно.

Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Амлалтын энэ хүснэгтийг өөрийн бүлгийн гишүүдийн нэртэй самбар дээр зур (доорх жишээг үзнэ үү).

ШИНЭ!

Бүлгийн гишүүний нэр	Би “Би 30 секундэд” танилцуулгаа наад зах нь 20 хүнд хэлсэн (Тоог бич)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глория	28	Т	Т	Т

Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч утг.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

ШИНЭ!

Цугларалт эхлэх үед:

ШИНЭ!

- Бүлгийн гишүүдийн холбоо барих мэдээллийн хувийг тарааж өг (өмнөх цугларалтын үеэр авсан).
- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирлаар эхэл (хүсвэл дуулал дуулж болно).
- Хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 2-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.



ТАЙЛАГНА

БИ ӨГСӨН АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

Цаг: Тайлагна хэсэгт 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Ярилц: Баруун гар талд байгаа эшлэлийг унш. Энэ нь манай бүлэгт ямар хамаатай вэ?

Дадлага хий: Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Бүх амлалтаа биелүүлсэн хүмүүст зориулж алга таш.)

Унш: Одоо бүгдээрээ бос. Бид өгсөн бүх амлалтаа биелүүлэхийг хичээх ёстой. Энэ бол бие даасан хүмүүсийн эзэмших чухал дадал хэвшлийн нэг болно.

Бүгдээрээ зогсоод, уриагаа хамтдаа уншицгаая. Энэ уриа бидэнд бүлгийн зорилгыг сануулдаг болно.

“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”

Сургаал ба Гэрээ 104:15

Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.

Унш: Сууцгаая.

Ярилц: Та нар энэ долоо хоногт өөрсдийн амлалтыг биелүүлж байх үедээ юу сурч мэдэж авсан бэ? Бид хэрхэн тусалж чадах вэ? Хамтдаа зөвлөлдөж, нэг нэгэндээ ажил хайхад нь тусалцгаая. Энэ нь энэ цугларалтын хамгийн чухал хэлэлцүүлэг юм!

Та нар “Би 30 секундэд” танилцуулгыг хүмүүст танилцуулж байх үедээ юу сурч мэдэж авсан бэ? Та нар үүнийг сайжруулсан уу? Та хэрхэн холбоо тогтоож, эргэн шалгах тухайгаа бичсэн үү?

Ажил эрчимтэй хайх аргаас туршиж үзсэн хүн байна уу? Үр дүн гарсан уу?



“Гүйцэтгэлийг хэмжвэл, гүйцэтгэл сайжирдаг. Гүйцэтгэлийг хэмжиж, тайлагнаж байвал сайжрах хурд нэмэгддэг.”

**(ТОМАС С.МОНСОН,
Conference Report, 1970
оны 10-р сар, 107)**



СУРАЛЦ

БИ ХЭРХЭН ӨӨРИЙГӨӨ БУСДАД ОНЦГОЙ СЭТГЭГДЭЛ ТӨРҮҮЛЭХҮЙЦ ТАНИЛЦУУЛАХ ВЭ?

Цаг: Суралц хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Үз: “Ярилцлага” (Видео бичлэг байхгүй бол 32-р хуудсыг унш.)

Ярилц: Энэ хүмүүс ажилд орсон болов уу?

Ярилцлагын үеэр асуулганд тааруу хариулт өгч байгаа эсэхийг та нар сонсоод л мэдэж чадна! Гэхдээ та нарт заримдаа ярилцлаган дээр сайн хариулт өгөхөд хэцүү байдаг уу?

Унш: ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Би хэрхэн өөрийгөө бусдад онцгой сэтгэгдэл төрүүлэхүйц танилцуулах вэ?

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Давуу талуудын тодорхойлолт бэлтгэж, холбоо тогтоох хүмүүстэй уулзахдаа хэрэглэнэ.

Унш: Өмнөх цугларалт дээр бид “Би 30 секундэд” танилцуулга хэрхэн хүний анхаарлыг татдаг талаар ярилцсан. Бидний дараагийн алхам бол “Давуу талуудын тухай тодорхойлолт” бичих явдал юм. Энэ нь бидний давуу чанаруудыг ажил олгогчид болон бусдад харуулдаг.

Давуу талуудын тухай тодорхойлолт нь товч намтарт болон ярилцлагуудад хүч нэмдэг. Энэ нь биднийг таньдаг хүмүүстэйгээ ярилцахад тусалдаг. Энэ нь түүнчлэн ажлын байраа хадгалан үлдэхэд мөн амжилт гаргахад ч тусалж чадна.

Давуу талуудын тухай тодорхойлолтын дөрвөн үндсэн хэсгийг уншицгаая.

ДАВУУ ТАЛУУДЫН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТЫН ҮНДСЭН ДӨРВӨН ХЭСЭГ

Үнэ цэнэ, ур чадвар, эсвэл давуу талаа тодорхойлох

Нэг тодорхой жишээ эсвэл ололт амжилтын жишээ өгөх

Гарсан үр дүнг хэлэх

Өөрийн үнэ цэнийг ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад тохируулах

БИ ДАВУУ ТАЛУУДЫН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТЫГ ХЭРХЭН БИЧИХ ВЭ?

Унш: Викториа боломжит ажил олгогчтой таван минутын ярилцлага хийхээр тохирчээ. Ажил олгогч түүнээс маркетингийн туршлагын талаар асуухад тэр давуу талуудын тухай тодорхойлолтынхоо нэгийг ашигласан.

ВИКТОРИАГИЙН ДАВУУ ТАЛУУДЫН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ

1 Би бүтээлч бөгөөд үр дүнг зорилгоо болгон ажилладаг! Жишээлбэл: 2 Би ABC цахилгааны компанид маркетингийн шинэ төлөвлөгөө хийж, товхимол гаргасан ба энэ нь 3 сар тутмын борлуулалтыг 5 хувиар нэмэгдүүлсэн. Би 4 танай компанийн борлуулалтыг үүнтэй адилаар нэмэгдүүлж чадна гэдэгтээ бүрэн итгэлтэй байна.

1 Ур чадвар эсвэл хүчтэй талаа тодорхойл 2 Тодорхой жишээ ав 3 Үр дүнг хэл 4 Эдгээрийг хэрэгцээ шаардлагад тохируул

Ярилц: Энэ тодорхойлолт нь Викториаг ажил хайхад хэрхэн туслах вэ?

Унш: Эргэж ирсэн номлогч, жижиг бизнес эрхлэгч, ээж гэсэн ажил хайж буй хүмүүст зориулсан давуу талуудын тухай тодорхойлолтыг доор харуулав. Тэдгээрийг унш. Тодорхойлолтын дөрвөн хэсгийг хэрхэн хамтад нь оруулсныг анхаар.

1. УР ЧАДВАР	2. ЖИШЭЭ (Тодорхой жишээ)	3. ҮР ДҮН (Тодорхой жишээ)	4. ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД ТОХИРУУЛ
Би баг бүрдүүлж мөн багаа идэвхжүүлж чадна.	Жишээлбэл: Би Сүмийн бүрэн цагийн сайн дурын ажилтны хувьд хоорондоо нэгдмэл биш, зорилгодоо хүрч чадахгүй байсан найман сайн дурын ажилтнаас бүрдсэн баг удирдах даалгавар авсан юм.	Би сургалт хурал хийж, тэднийг нэг нэгнээ хүндэлж, зорилго тавихад, мөн тэдгээр зорилгодоо хүрэхэд нь тусалсан.	Би танай багийг нэгдмэл болгож, тавьсан зорилгоо давуулан биелүүлэхэд нь тусалж чадна.
Би асуудал шийдвэрлэх тал дээр туршлагатай.	Жишээлбэл: Бид гэр бүлийн бизнесийнхээ зарлагыг сайн тооцож чадахгүй байсан юм. Би бүртгэлээ илүү сайн хөтлөн, өдөр тутмын зардлуудаа тооцох шийдвэр гаргасан.	Бид бүртгэлээ ажиглаж, зарлагаа хянаад, бараа нийлүүлэгчээ бидэнд хэлэлгүйгээр бага зэрэг илүү мөнгө авч байсныг мэдсэн юм.	Би асуудал шийдвэрлэх эдгээр ур чадвараа ашиглан та нарт тулгараад буй ямар ч асуудлыг шийдвэрлэж, сайн үр дүн авчирна гэдэгтээ итгэлтэй байна.
Би зохион байгуулах чадвартай.	Жишээлбэл: Би ээж хүний хувьд гурван хүүхдийнхээ хичээл сурлага, бусад хийх зүйлийг нь тэнцвэртэй байлгадаг.	Эдгээр хуваарийн дагуу ажилласнаар бүх хүүхэд маань сургуулиа амжилттай төгсөж мөн ажил хөдөлмөр хийж сурсан.	Би удирдах энэ ур чадвараа ашиглан, танай компанийн ажлыг хуваарийн дагуу явуулж чадна.

2: Би хэрхэн өөрийгөө бусдад онцгой сэтгэгдэл төрүүлэхүйц танилцуулах вэ?

Дадлага хий: Хувийн давуу талуудын тухай тодорхойлолт бичихэд энэ хуудсыг ашигла. Тэдгээрийг дараах хүснэгтэд бич. Та бүлгийн өөр нэг гишүүнтэй хамт ажиллаж болно.

1. УР ЧАДВАР	2. ЖИШЭЭ (Тодорхой жишээ)	3. ҮР ДҮН (Тодорхой жишээ)	4. ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД ТОХИРУУЛ

Дадлага хий: Та давуу талуудын тухай наад зах нь хоёр тодорхойлолт бичсэнийхээ дараа тэдгээрийг бүлгийн гишүүн дээр турш. Үүнийг ээлжлэн хий. Өөртөө итгэлтэй болглоо тэдгээрийг чанга чанга хэл. Дараагийн цугларалт болохоос өмнө наад зах нь таван давуу талынхаа тухай тодорхойлолт бич.

Унш: Та хэн нэгэнтэй ажлын талаар ярихдаа “Би 30 секундэд” танилцуулгаар эхэлж болно. Уг хүн нь ажил олгогч эсвэл таны тусламж хүссэн хүн байж болно. Дараа нь уг хүн танд нийтлэг асуулт тавьж магадгүй. Эдгээр асуултанд хариулахад танд давуу талуудын тухай тодорхойлолт хэрэг болно. Та дараагийн цугларалт болохоос өмнө давуу талуудын тухай тодорхойлолтоо олон хүнтэй хуваалцана.

Дадлага хий: Бүлгээрээ эдгээр зааврыг унш. Зааврыг уншсаныхаа дараа үйл ажиллагааг эхэл. Энэ хэсгийг хийж гүйцэтгэхэд арваас илүү минут зарцуулах хэрэггүй.

1. Бүх хүн босоод, түргэвчилсэн дадлага хийж болох зайтай газар оч. Хүн бүр өөд өөдөөсөө харсан байх ёстой.
2. Эхний хүн нь дараахтай адил нэг нийтлэг асуулт тавина:
 - Та өөрийнхөө талаар ярих уу?
 - Бид яагаад таныг ажилд авах ёстой вэ?
 - Таны хамгийн сайн давуу тал юу вэ?
 - Би таньдаг хүмүүстээ таны талаар юу гэж хэлэх вэ?
3. Хоёр дахь хүн хариулт болгон давуу талуудын тухай тодорхойлолтоо хэлнэ.
4. Үүнийг ээлжлэн хий. Хоёр дахь хүн өөр нэг нийтлэг асуулт тавьж, эхний хүн давуу талуудын тухай тодорхойлолтоо ашиглан хариулна.
5. Нэг нэгэндээ үнэлгээ өг: Уг тодорхойлолт дөрвөн хэсэгтэй байсан уу? Энэ нь үнэн, итгэл төрүүлэм байсан уу?
6. Дараа нь хүн бүр хамтрагчаа солиод, үүнийг давтан хий. Дахин хий!
7. Хүн бүр үүнийг дөрвөн удаа хийх хүртэл аль болох хурдан хий.

Ярилц: Та асуултанд хариулахын тулд давуу талуудын тухай тодорхойлолтоо ашигласан уу? Эдгээр асуултын өөр ямар хувилбарууд байж болох вэ? Ярилцлага хийж буй хүн өөр ямар асуулт тавьж болох вэ?

САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА: БИ СӨРӨГ ЗҮЙЛИЙГ ХЭРХЭН ЭЭРЭГ БОЛГОХ ВЭ?


(ҮҮНИЙГ ЦУГЛАРАЛТЫН ҮЕЭР ХИЙХГҮЙ.)

Хэрэв хүсвэл та долоо хоногийн дундуур энэ үйл ажиллагааг хийж болно:

Та давуу талуудын тухай тодорхойлолтоо ашиглан, сөрөг асуулт, нөхцөл байдлыг эерэг боломжууд болгож чадна. 33-р хуудсан дээрх Эх сурвалж хэсгийг судал.

БИ ДАВУУ ТАЛУУДЫН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТОО ХААНА АШИГЛАХ ВЭ?

Унш: Бидэнд шинээр бичсэн давуу талуудын тухай тодорхойлолт ба “Би 30 секундэд” танилцуулга гэсэн сайн арга хэрэгслүүд байна. Гэхдээ бид эдгээрийг сонсох хүнийг хэрхэн олох вэ? Үүний нууц нь хүн бүртэй ярилцах явдал мөн. Дараа нь *тэднээс* таньдаг хүмүүстэйгээ ярихыг хүс. Энэ бол “сүлжээ” бөгөөд энэ нь өөрийн гэсэн борлуулалтын багийг бүрдүүлэхтэй адил юм.



Дадлага хий: Хажуудаа сууж буй хүнтэй ярилцахын тулд сандлаа ойртуул.

1. Та дараагийн цугларалт болохоос өмнө уулзах бүх хүндээ “Би 30 секундэд” танилцуулгыг болон давуу талуудын тухай тодорхойлолтоо хэлэх талаараа ярилц. Хэдэн нэр жагсааж бич:

2. Илүү олон хүнтэй холбоо барихын тулд сүлжээгээ хэрхэн өргөжүүлэх талаараа ярилц. Санаагаа энд бич:

Дадлага хий: Дараагийн цугларалт болохоос өмнө та таньдаг хүмүүстэйгээ уулзаж, давуу талуудын тухай тодорхойлолтоо ашиглана. Дараа нь тэднээс таньдаг хүмүүстэйгээ ярихыг хүс. “Би 30 секундэд” танилцуулга болон давуу талуудын тухай тодорхойлолт нь сүлжээгээ өргөжүүлэхэд туслах гайхалтай хоёр арга хэрэгсэл юм. Таны ажил хайх байдал сайн болж байна.

САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА: АЖИЛ ЭРЧИМТЭЙ ХАЙХ

(ҮҮНИЙГ ЦУГЛАРАЛТЫН ҮЕЭР ХИЙХГҮЙ.)

Хэрэв хүсвэл та долоо хоногийн дундуур энэ үйл ажиллагааг хийж болно:

Илүү хурдан ажил олохын тулд 15-р хуудсан дээрх “Ажил эрчимтэй хайх нь” хэсгийг судал. Өдөр бүр 15 эх сурвалж олж, 10 хүнтэй холбоо тогтоож, 2 хүнтэй уулзана. Энэ бүгдийг туршаад үз.



ТУНГААН БОД

БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Цаг: Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцахыг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

Ярилц: Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

“Харин Их Эзэн бүх зүйлийг эхлэлээс нь мэдэх буюу; иймийн тул, тэрээр хүмүүний үрсийн дунд өөрийн бүхий л үйлүүдээ гүйцэлдүүлэх замыг бэлтгэх ажээ.”

1 НИФАЙ 9:6



АМЛАЛТ ӨГ

БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

Цаг: Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

Хамтрагчийн нэр

Холбоо барих мэдээлэл

Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.

МИНИЙ АМЛАЛТУУД

Би дараагийн цугларалт болохоос өмнө давуу талуудын тухай тодорхойлолтоо олон хүнтэй хуваалцана. (Эдгээрийн зарим нь урьд өмнө холбоо барьсан хүмүүстэй дахин хийх уулзалт байх ёстой.)

Зорилгоо дугуйл: 20 30 40

Би өнөөдрийн “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

Миний гарын үсэг

Хамтрагчийн гарын үсэг

БИ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

Дадлага хий: Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх зайд “Тийм”, “Үгүй” гэж, эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

<p>Би “Би 30 секундэд” танилцуулгаа наад зах нь 20 хүнд хэлсэн (Тоог бич)</p>	<p>“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)</p>	<p>Хадгалам-жиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)</p>	<p>Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)</p>
<p></p>	<p></p>	<p></p>	<p></p>

Унш: Түүнчлэн “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлынхоо арын хуудсан дээр зарлагаа тэмдэглээрэй.

Бидний дараагийн цугларалтын үеэр зохицуулагч самбар дээр амлалтын хүснэгт зурна (дээрхтэй адил). Бид цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлыг хүснэгтэнд бичнэ.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын нэг сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. Түүнд даалгасан материалаас өөр нэмэлт материал авч ирэх хэрэггүй гэдгийг сануул. (“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 13-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа srsfeedback@ldschurch.org хаягаар илгээнэ үү.

Эх сурвалж

ЯРИЛЦЛАГА

Дүрүүдийг сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

ЯРИЛЦЛАГА ХИЙЖ БУЙ ХҮН: Та өөрийнхөө талаар ярих уу?

1 ДЭХ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Юу хийх дуртайгаа хэлээч гэж үү? Яриад байх зүйл бараг л байхгүй. Надад хобби эсвэл сонирхол гэхээр юм байхгүй. Би ер нь юу ч хийдэггүй.

2 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Юу л даа . . . , би . . .

3 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Бололгүй яах вэ. Би бялдаржуулах урлагаар хичээллэхэд ихээхэн цаг зарцуулдгийг та харж байгаа байх. Би бас уураа хянаж сурах хичээлд суух хэрэгтэй. Гэхдээ хэн л ийм ангид суухыг хүсэх вэ дээ? Миний юу хэлэх гээд байгааг та ойлгож байгаа биз дээ?

1 ДЭХ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Эсвэл та надаас ажил дээр ямар байдгаа яриасай гэж хүсэж байна уу? Би нэг ажил дээр удаан хугацаагаар тогтвортой ажиллаж байгаагүй болохоор хэлэх зүйл алга даа. Би амархан үйддаг болохоор ажилдаа ирэхээ больдог. . . . Би ингэж хэлэх ёсгүй байсан байж магадгүй.

2 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Юу л даа . . .

3 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Уураа хянаж сурах ангид багшилдаг залуу ёстой дургүй хүргээд байдаг юм. Би түүнийг болгоод өгч чадна л даа. Миний дарга хэн болох вэ? Та юу? Та хүмүүсийг завгүй байгаа эсэхийг үргэлж шалгаад байдаг хүн биш биз дээ? Ажилчидтайгаа хүүхдүүдтэй харьцаж байгаа юм шиг харьцдаггүй биз дээ? Сүүлд хамт ажиллаж байсан дарга минь тийм хүн байсан. Надад энэ нь таалагддаггүй байсан.

ЯРИЛЦЛАГА АВЧ БАЙГАА ХҮН: Бид яагаад таныг ажилд авах ёстой вэ?

2 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Яагаад намайг ажилд авах ёстой вэ гэж үү? . . .

1 ДЭХ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Надад ажил хэрэгтэй байна. Миний ээж өчигдөр энд ирэхдээ энэ талаар танитай ярилцсан гэж бодсон юмсан. Ээж минь намайг ажилд ор гэж хэлсэн. Та сонссон шүү дээ.

3 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Намайг ажилд авахгүй бол том алдаа болно. Би энд зарим зүйлийг өөрчлөх хэрэгтэй юм байна гэж бодож байна. Та нарын бизнес дампуурахгүй ажиллаж байгаад гайтаж байна. Би энэ бүхнийг засаж чадна. Нээрэн шүү. Бизнесийг чинь хөл дээр нь босгосонд та надад талархах болно.

2 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Яагаад гэвэл. . . нөгөө

ЯРИЛЦЛАГА ХИЙЖ БУЙ ХҮН: Таны хамгийн том сул тал юу вэ?

3 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Надад ямар ч сул тал байхгүй. Таны сул тал юу вэ? Би иймэрхүү асуултанд дургүй.

2 ДАХЬ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: Сул талууд гэнэ ээ? Бодъё . . .

1 ДЭХ АЖИЛ ХАЙЖ БУЙ ХҮН: За байз . . . хулгай хийх юм байна. Хулгай хийхгүй байх гэж хэлэх гэсэн юм. Энэ яг ч хулгай байгаагүй юм. Үүнийг яривал их урт түүх болно. Би авсан зүйлээ буцаагаад авчрах гэж байсан юм л даа. Дарга маань үүнийг надад түр хугацаагаар эзлүүлэх байх гэж бодсон.

24-р хуудас руу буцаж оч

БИ СӨРӨГ ЗҮЙЛИЙГ ХЭРХЭН ЭЭРЭГ БОЛГОХ ВЭ? (САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА)

Ярилц: “Таны хамгийн том сул тал юу вэ?” гэсэн асуултанд та хэрхэн хариулдаг вэ? Глориягийн хариултыг унш.

“Би цагаа үр бүтээлтэй зарцуулах чадвараа сайжруулах гэж хичээж байгаа. Би хуанли ашиглах нэг арга олсон бөгөөд энэ нь надад тусалдаг учраас үүнийг өдөр бүр ашигладаг. Саяхан би чухал ажил ихтэй байсан ч нэг том худалдааны төслийг зах зээлд хугацаанд нь нэвтрүүлж чадсан.

Унш: Глория юу хийснийг анхаар:

- Тэр олон хүнд байдаг нийтлэг сул талыг ярьсан.
- Тэр уг сул талаа хэрхэн ялан дийлж байгаагаа тодорхой хэлсэн.
- Мөн давуу талуудын тухай тодорхойлолтоосоо мэдээлэл нэмж оруулсан.

Дадлага хий: Үүнийг гэр бүлийнхээ гишүүнтэй юм уу найзтайгаа хий. Танаас сөрөг агуулгатай зүйл асуухыг тэднээс хүс. Олон хүнд байдаг нийтлэг сул талыг хэлж хариул. Энэ сул талаа хэрхэн ялан дийлснээ ярь. Давуу талуудын тухай тодорхойлолтоосоо мэдээлэл нэмж оруул.



3

*Би хөдөлмөрийн
“далд” зах зээл рүү
хэрхэн орох вэ?*

Ажил хайх нь

ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд.

Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Энэ амлалтын хүснэгтийг самбар дээр зур.

Бүлгийн гишүүний нэр	Би “Би 30 секундэд” танилцуулгаа наад зах нь 20 хүнд хэлсэн (Тоог бич)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгалам-жиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глория	32	T	T	T

Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч угт.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

Цугларалт эхлэх үед:

- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирлаар эхэл (хүсвэл дуулал дуулж болно).
- Хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 3-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.



ТАЙЛАГНА

БИ ӨГСӨН АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

Цаг: Тайлагна хэсэгт 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Алга таш.)

Унш: Одоо бүгдээрээ бос. Бүгдээрээ бүлгийнхээ уриаг хамт уншицгаая.

“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”

Сургаал ба Гэрээ 104:15

Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.

Унш: Сууцгаая.


Ярилц: Та нар давуу талуудын тодорхойлолтыг хүмүүст танилцуулж байх үедээ юу сурч мэдэж авсан бэ? Та нар үүнийг сайжруулсан уу? Та хэрхэн холбоо тогтоож, эргэн шалгах тухайгаа бичсэн үү? Ажил эрчимтэй хайх аргаас туршиж үзсэн хүн байна уу? Үр дүн гарсан уу?



СУРАЛЦ

“ДАЛД” АЖЛЫН БАЙРУУД ГЭЖ ЮУ ВЭ?

- Цаг:** Суралц хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- Үз:** “Өрсөлдөөн багатай газарт хайгуул хий” (Видео бичлэг байхгүй бол 48-р хуудсыг унш.)
- Унш:** Доорх загасчлах бүдүүвч зурган дээрх үгсийг хамтдаа уншицгаая. Загас нь ажлын байруудыг төлөөлдөг. Ихэнх загас буюу ихэнх ажил хаана байгааг анхаар.
- Ярилц:** Аль хүн хамгийн их загас барьж чадах вэ? Тэр хүнийг дугуйл. “Далд” ажлын байрууд хаана байдаг вэ?
- Унш:** Хөдөлмөрийн далд зах зээл нь уламжлалт зах зээлийг бодвол илүү их боломжтой байдаг. Бид хаанаас ажил хайж байна вэ? Бид хаанаас ажил хайх ёстой вэ?



Унш: ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Би хөдөлмөрийн зах зээл дээрх “далд” ажлын байруудыг хэрхэн олох вэ?
ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Ажил олгогч байж болох хүмүүстэй нүүр тулсан уулзалтууд хийнэ.

Энэ цугларалтын үеэр бид энэ асуултанд хариулж, мөн энэ чухал үйлдлийг хийхэд бидэнд туслах ур чадварт суралцаж, дадлага хийх болно.

“ДАЛД” АЖЛЫН БАЙРУУД ХААНА БАЙДАГ ВЭ?

Үз: “Хамгийн үр дүнтэй эх сурвалж” (Видео бичлэг байхгүй бол 48-р хуудсыг унш.)

Унш: Ажил хайх зарим стратеги нь бусдаасаа илүү үр дүнтэй байдаг. Зарим оронд тодорхой арга замаар ажил олдог хүмүүсийн тоо доорх хүснэгттэй төстэй байж болно. Таны амьдардаг газар өөр байж болох юм.

Дадлага хий: Бүлгээрээ тэдгээр асуултанд хариул:
1. Энэ хүснэгтэд үзүүлснээр, ихэнх хүн ажил хайхын тулд ямар арга хэрэглэдэг вэ?
2. Ажил олоход аль арга хамгийн амжилттай байдаг вэ?


АРГА БАРИЛ	ХҮМҮҮС АЖИЛ ХАЙХ ҮЕДЭЭ ЦАГАА ЗАРЦУУЛДАГ ГАЗАР	ХҮМҮҮС АЖЛАА ОЛДОГ ГАЗАР
Ажлын зар/Интернэт	65%	14%
Ажилд зуучлах засгийн газрын эсвэл хувийн компани	27%	21%
Компаниудтай хувиараа холбоо тогтоох	3%	30%
Аман холбоо (хувиараа ба бусдаар дамжуулан холбоо тогтоох)	5%	35%

Гэсэн хэдий ч эдгээр боломжийг үл ойшоовол нийт ажлын 35 хувийг алдаж магадгүй.

Энэ бол далд ажлын байр юм. Үүн дээр анхаарлаа төвлөрүүлбэл өрсөлдөөний 92 хувиас зайлсхийж чадна.

БИ ХЭРХЭН ДАЛД АЖЛЫН БАЙРУУДЫГ ОЛОХ ВЭ?

Унш: Бидэнд далд ажлын байранд хүрэх түлхүүр байна. Энэ нь хувиараа холбоо тогтоохыг шаарддаг. Бид (1) “Би 30 секундэд” танилцуулга, (2) давуу талуудын тухай тодорхойлолт, (3) өөрсдийн өргөжиж буй сүлжээг ашигласнаар хамгийн сайн холбоог тогтоож чадна. Сүлжээ гэдэгт бидний мөн тэдний таньдаг хүмүүс багтдаг гэдгийг бид өнгөрсөн цугларалт дээр мэдэж авсан.



Үз: “Сүлжээгээ өргөжүүлэх нь” (Видео бичлэг байхгүй бол 49-р хуудсыг унш.)

Ярилц: Та өнгөрсөн цугларалтаас хойш “Би 30 секундэд” танилцуулга болон давуу талуудын тухай тодорхойлолтоо ашигласан уу? Та таньдаг хүмүүстэйгээ ярилцахыг танилуудаасаа хүссэн үү?

- Дадлага хий:** Манай бүлэг бол сүлжээгээ өргөжүүлэх анхны эх сурвалж юм. Яг одоо сүлжээгээ өргөжүүлж эхэлье. Доорх зааврыг уншаад эхэл:
1. Босоод, хажуудаа байгаа хүнтэй ярь.
 2. Уг хүнд “Би 30 секундэд” танилцуулгаа хэлж, дараах хоёр асуултаар төгсгө: “Олон танилтай болоход маань туслах ямар хүнийг та таних вэ?” “Та тэдгээр хүнтэй ярилцаж, тэднээс тусламж хүсэх үү?”
 3. Дараагийн хуудасны сүлжээний жагсаалтан дээр байгаа хүмүүсийн нэрийг бичиж аваад, дараагийн цугларалт болохоос өмнө бодож байгаад дахин нэрс өгөхийг тэднээс хүс.
 4. Дараа нь ээлж ээлжээр үүнийг дахин хий.
 5. Суудлаа сольж, бүлгийн бусад гишүүнтэй үүнийг хий.
 6. Дараагийн хуудсан дээр аль болох олон хүний мэдээллийг бич.
 7. Цугларалтын дараа үүнийг таньдаг хүмүүс дээрээ турш.
 8. Нэн чухал гэсэн багананд холбоо барих хүмүүсээ 1-20 хүртэл дугаарла.

Сүлжээгээ өргөжүүлэх тухай зөвлөгөө

1. Таньдаг хүмүүсээс ажлын боломж, мэдээлэл болон санаануудыг асуу.
2. Үргэлж илүү их мэдээлэл хүс.
3. Үнэн зөв тэмдэглэл хөтөлж, дараа нь үйлдэл хийдэг бай.

БИ ХҮМҮҮСИЙГ АЖИЛД АВДАГ МЕНЕЖЕРТЭЙ ХЭРХЭН УУЛЗАХ ВЭ?

Унш: Сүлжээгээ өргөжүүлэх нь биднийг хүмүүсийг ажилд авч буй бизнес рүү хөтлөх болно. Гэхдээ бид ажилд авах шийдвэр гаргадаг хүнтэй уулзах хэрэгтэй.

Дадлага хий: Бүлгээрээ дадлага хийцгээе.

1. Хэн нэгнийг ажил хайж буй хүн болгон томил. Энэ хүн “Би 30 секундэд” танилцуулга ба нэг асуулт мөн давуу талуудын тухай тодорхойлолтоо ажил олгогчид хэлэхэд бэлэн байх ёстой.
2. Хоёр хүнийг ажилтан болгож томил: ажилтан 1, ажилтан 2
3. Өөр нэг хүнийг менежер болгон томил.
4. Энэ дөрвөн хүнийг босож зогсоно уу хэмээн урь. Зохицуулагч энэхүү жүжигчилсэн тоглолтын эхний мөрийг уншина. Дараа нь бусад нь өөр өөрсдийн үгийг уншина.

Зохицуулагч: Энэ ажил хайж буй хүн ажиллахыг хүсэж буй дэлгүүрт эсвэл оффист орж ирэв. Тэр эхний тааралдсан ажилтантай ярилцав.

Ажил хайж буй хүн: Сайн байна уу? Хариуцлагатай менежер нь хэн байна вэ?

1 дэх ажилтан: Ноён Валэнзуэла байгаа, гэхдээ одоо хаана байгааг би мэдэхгүй. Та тэнд байгаа туслахаас нь асууж болно.

Ажил хайж буй хүн: Баярлалаа. [2 дахь ажилтан руу харна.]

Ажил хайж буй хүн: Сайн байна уу? Ноён Валэнзуэла хаана байгааг хэлээд өгөхгүй юү?

2 дахь ажилтан: Тэр ямар нэг зүйл авахаар явсан. Тэр удахгүй ирэх ёстой. Өө, тэр ороод ирлээ.

Ажил хайж буй хүн: Гийм байна. Баярлалаа. [Ноён Валэнзуэла-тай ярилцана.]

Ажил хайж буй хүн: Ноён Валэнзуэла, өглөөний мэнд. Намайг _____ [нэр] гэдэг. [“Би 30 секундэд” танилцуулгаа хэлж мөн асуултаар төгсгөнө.] Над шиг үр чадвартай хүн таны бизнест хэрхэн тусалж чадах вэ?

Менежер: Бид тан шиг хүнийг хайж эхэлж байсан юм. Надад нэг минутын зав байна. Надад өөрийнхөө талаар товчхон хэлэхгүй юү.

Ажил хайж буй хүн: [Давуу талуудын тухай тодорхойлолтоо хэлнэ.] Таныг завгүй байгааг би ойлгож байна. Бид өнөөдөр үдээс хойш эсвэл маргааш уулзаж, илүү дэлгэрэнгүй ярилцаж болох уу?


3: Би хөдөлмөрийн “далд” зах зээл рүү хэрхэн орох вэ?

Ярилц: Хэрэв менежер “үгүй” эсвэл “дараа эргээд ирээрэй” эсвэл “өргөдөл бөглө” гэж хэлбэл, ажил хайж буй хүн юу гэж хэлж болох вэ?

Унш: Бид нөхцөл байдал бүрд дасан зохицох хэрэгтэй.

Дадлага хий: Бүгд босоод, дөрвөн хүнтэй багуудад хуваагд. Жүжигчилсэн тоглолтыг давтан хий. Ингэснээр хүн бүр ажил хайж буй хүний дүрд тоглож чадна.

Унш: Бидэнд хүмүүстэй холбоо барихдаа ашиглах “Би 30 секунд,” давуу талуудын тухай тодорхойлолт, менежертэй хийх уулзалт



зэрэг хэд хэдэн үр дүнтэй арга хэрэгсэл байна. Түүнчлэн та нар 33-р хуудаснаас сөрөг агуулгатай зүйлүүдийг хэрхэн эерэг болгохыг судалж болно.

Ярилц: Та нар дараагийн цугларалтаас өмнө олон амжилттай уулзалт хийхийн тулд эдгээр арга хэрэгслийг хэрхэн ашиглах вэ?

Дадлага хий: 50-р хуудас руу буцаж очоод, ажил хайх хүчин чармайлтаа хэрхэн хэмжих талаар ээлжлэн унш. Дараа нь энэ хуудсан дээр дахин оч.



ТУНГААН БОД

БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Цаг: Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцахыг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

Ярилц: Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

“Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно”

СУРГААЛТ ҮГС 3:5–6



АМЛАЛТ ӨГ

БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

Цаг: Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

Хамтрагчийн нэр

Холбоо барих мэдээлэл

Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.

МИНИЙ АМЛАЛТУУД

Би өөрийнхөө таньдаг хүмүүсээс болон тэдний танилуудаас (миний сүлжээ) наад зах нь 30 хүнд “Би 30 секундэд” танилцуулга болон давуу талуудын тухай тодорхойлолтоо хэлэх болно. (Холбоо барих хүмүүсээ 50-51-р хуудсан дээр бич. Эдгээрийн зарим нь өмнө нь холбоо барьсан хүмүүстэй дахин хийх уулзалт байх ёстой.)

Зорилгоо дугуйл: 30 40 50

Би таньдаг хүмүүстэйгээ болон менежертэй уулзахыг хичээж, наад зах нь 10 боломжит ажил олгогчтой нүүр тулж уулзахыг хичээнэ. (Холбоо барих хүмүүсээ 50-51-р хуудсан дээр бич.)

Зорилгоо дугуйл: 10 15 20

Би өнөөдрийн “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

Миний гарын үсэг

Хамтрагчийн гарын үсэг

БИ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

Дадлага хий: Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх зайд “Тийм”, “Үгүй” гэж, эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Наад зах нь 30 хүнтэй холбоо барьсан (Тоог бич)	Наад зах нь 10 боломжит ажил олгогчтой уулзсан (Тоог бич)	“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийн- хэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгалам- жиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

Унш: Түүнчлэн “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлынхоо арын хуудсан дээр зарлагаа тэмдэглээрэй.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” дээрх сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. (“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 13-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа srsfeedback@ldschurch.org хаягаар илгээнэ үү.

Эх сурвалж

ӨРСӨЛДӨӨН БАГАТАЙ ГАЗРААР ЭРЭЛ ХАЙГУУЛ ХИЙ

Дүрээ сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

КВАМЭ: Өө, арай ч дээ. Миний орохыг хүссэн ажилд 200 гаруй хүн өргөдөл өгсөн байна. Надад ямар ч боломж байхгүй юм байна.

КОФИ: Квамэ, бид хоёрын бага байхдаа загасчилдаг байсан газрыг чи санаж байна уу?

КВАМЭ: Тийм ээ. Энэ нь модоор хүрээлэгдсэн нууцхан сайхан газар байсан шүү. Энэ газрыг олоход маш хэцүү байсан. Гэхдээ одоо хүн бүр үүнийг мэддэг. Одоо тэнд

олон хүн очдог болохоор загас баригдахгүй болсон байна лээ.

КОФИ: Чи ажил хайхдаа яагаад хүн бүрийн “загасчилж” байгаа газар “загасчилдаг” юм бэ? Чи өрсөлдөөн багатай газрыг эрж хайвал яасан юм? Чи далд ажлын байруудыг олж харахгүй байна гэж би бодож байна. Загас байгаа газарт загасчил!

38-р хуудас руу буцаж оч

ХАМГИЙН ҮР ДҮНТЭЙ ЭХ СУРВАЛЖ

Дүрээ сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

КОФИ: Би чамд сонин авчирлаа.

КВАМЭ: Би сонин уншихаа болиод удаж байна. Хэлсэн зүйлээ санаж байна уу? Би өрсөлдөөн багатай газар загасчилж байгаа.

КОФИ: Сайн байна, чи хамгийн үр дүнтэй эх сурвалж дээр анхаарлаа төвлөрүүлэх

хэрэгтэй. Гэхдээ сонин дээр сайн сайн ажил гарсан байдаг. Бид бүх боломжийг ашиглах хэрэгтэй. Энэ нь хамгийн үр дүнтэй эх сурвалж дээр зохих хэмжээний цагийг зарцуулна гэсэн үг юм.

39-р хуудас руу буцаж оч

СҮЛЖЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ НЬ

Дүрээ сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

КВАМЭ: Би өдөр бүр 10 хүнтэй холбоо тогтоохыг хичээж байгаа ч гэсэн шинээр хүн олоход улам хэцүү болж байна.

КОФИ: Сүүлийн хэдэн өдөр чамайг анзаараад байхад чи энэ бүгдийг ганцаараа хийх гээд л оролдоод байх юм. Чи сүлжээгээ ашиглавал илүү сайн үр дүнд хүрэх болно шүү дээ.

КВАМЭ: Сүлжээ гэнэ ээ?

КОФИ: Тийм ээ, чи нэг баг үүсгэх буюу боломжуудын талаар сонсоод чамд хэлж чадах сүлжээг өргөжүүлэх ёстой. Чи бусдад туслахад цаг гаргаж байвал тэд ч бас чамд туслах боломжтой байж магадгүй юм.

КВАМЭ: Би таньдаг хүн бүхэнтэйгээ нэгээс илүү удаа ярьж байгаа.

КОФИ: Зөв. Гэхдээ сүлжээ чинь зөвхөн чиний таньдаг хүмүүс байх албагүй. Үүнд: тэдний танилууд ч орох хэрэгтэй. Таньдаг хүмүүсээс танилуудтайгаа танилцуулахыг хүс.

КВАМЭ: Хмм. Гэхдээ би тэднийг танихгүй юм чинь юу ярих юм бэ? Энэ нь

таньдаг хүмүүстэйгээ ярихаас өөр шүү дээ. Юунаас эхлэх вэ?

КОФИ: Найзуудаасаа (1) чиний мэргэжлийн тухай мэдлэгтэй, (2) ажилд авах тал дээр нөлөө үзүүлж чадахуйц эсвэл (3) өөр олон хүн таньдаг хэн нэгнийг таньдаг эсэхийг нь асууж, үүнийг эхлүүл. Чиний сүлжээ илүү хурдан өргөжих болно. Сүлжээгээрээ дамжуулан ажлын боломжуудыг сонсох магадлал чинь өсөх болно. Тэд чамд далд ажлын байруудыг олоход туслах болно.

КВАМЭ: Гэхдээ би тэдэнд юу гэж хэлэх вэ?

КОФИ: Юу хэлэх гэхээсээ хэрхэн хэлэх нь илүү чухал юм. Чи өөрийгөө хэрхэн танилцуулж байгаа нь чухал. Чи “Би 30 секундэд” танилцуулга ба давуу талуудын тухай тодорхойлолтоороо дадлага хийвэл сайхан сэтгэгдэл үлдээх нь дамжиггүй.

КВАМЭ: За, яахав. Энэ нь шинэ боломжуудыг нээж ч болох юм.

40-р хуудас руу буцаж оч

ХҮЧИН ЧАРМАЙЛТАА ХЭМЖ

Дараагийн цугларалтаас өмнө сүлжээгээрээ дамжуулан ажил хайх наад зах нь 30 холбоо тогтоо. Би таньдаг хүмүүстэйгээ болон менежертэй уулзахыг хичээж, наад зах нь 10 боломжит ажил олгогчтой нүүр тулж уулзахыг хичээнэ.

Ажлын зар ба интернэтээр хайлтаа үргэлжлүүл мөн бие даах чадвар хөгжүүлэх төвөөр айлчил. Гэхдээ ажлын байрууд—далд ажлын байрууд хаана байгааг сана! Компаниудтай болон сүлжээгээрээ дамжуулан холбоо тогтоосон хүмүүстэй шууд ярилцахад ихэнх цаг зав, хүч чармайлтаа зарцуул.

Та холбоо тогтоосон хүмүүс болон уулзалтуудаа энэ хүснэгт дээр харж хянаж явах боломжтой (жишээ өгөв). Та холбоо тогтоосон хүмүүсээ болон уулзалтуудаа дараагийн хуудсан дээрх Эргэн холбоо барих гэсэн маягт дээр тэмдэглэ эсвэл өөр тэмдэглэлийн дэвтэр ашиглаж болно.

ЗАРЛАЛ/ИНТЕРНЭТ	АЖИЛД ЗУУЧЛАХ ЗАСГИЙН ГАЗРЫН ЭСВЭЛ ХУВИЙН КОМПАНИ	КОМПАНИУДАЙ ХУВИАРАА ХОЛБОО ТОГТООХ	СҮЛЖЭЭГЭЭР ДАМЖУУЛАН ОЛСОН ХҮМҮҮСТЭЙ ХУВИАРАА УУЛЗАХ
1. <i>Онлайнаар тооцоо бүртгэлийн ажилд бүртгүүлсэн</i>	1. <i>Ажилд зуучлах төвийн Глорияд “талархлын зурвас” илгээсэн</i>	1. <i>Accounting компанийн Майклтай дахин уулзах</i>	1. <i>Торо корпораци дээр Хосегийн найзтай уулзсан.</i>
2.	2.	2.	2.
3.	3.	3.	3.
4.	4.	4.	4.
5.	5.	5.	5.
	6.	6.	6.
	7.	7.	7.
	8.	8.	8.
		9.	9.
		10.	10.
		11.	11.
		12.	12.
		13.	13.
			14.
			15.

ХОЛБОО БАРИХ ХҮМҮҮСИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

ХОЛБОО БАРИХ

Хувь хүн эсвэл байгууллага: _____

Утас: _____ Хаяг: _____

Э-мэйл хаяг: _____ Намайг танилцуулсан хүн: _____

Би энэ хүнтэй холбоо тогтоосон Тийм Үгүй Огноо: _____

ЯРИЛЦСАН АСУУДАЛ:

1. _____

2. _____

3. _____

ДАРАА ХИЙХ ЗҮЙЛС:

1. _____ Дуусгасан байх (огноо): _____

2. _____ Дуусгасан байх (огноо): _____

3. _____ Дуусгасан байх (огноо): _____

ШИНЭ ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ:

1. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

2. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

ХОЛБОО БАРИХ

Хувь хүн эсвэл байгууллага: _____

Утас: _____ Хаяг: _____

Э-мэйл хаяг: _____ Намайг танилцуулсан хүн: _____

Би энэ хүнтэй холбоо тогтоосон Тийм Үгүй Огноо: _____

ЯРИЛЦСАН АСУУДАЛ:

1. _____

2. _____

3. _____

ДАРАА ХИЙХ ЗҮЙЛС:

1. _____ Дуусгасан байх (огноо): _____

2. _____ Дуусгасан байх (огноо): _____

3. _____ Дуусгасан байх (огноо): _____

ШИНЭ ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ:

1. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

2. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____



4

*Би шууд
сонгогдохын тулд
ямар байх ёстой вэ?*

Ажил хайх нь

ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд.

Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Энэ амлалтын хүснэгтийг самбар дээр зур.

Бүлгийн гишүүний нэр	Наад зах нь 30 хүнтэй холбоо барьсан (Тоог бич)	Наад зах нь 10 боломжит ажил олгогчтой уулзсан (Тоог бич)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глория	33	12	Т	Т	Т

Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч утг.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

Цугларалт эхлэх үед:

- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирлаар эхэл (хүсвэл дуулал дуулж болно).
- Хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 4-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.



ТАЙЛАГНА

БИ ӨГСӨН АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

Цаг: Тайлагна хэсэгт 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Алга таш.)

Унш: Одоо бүгдээрээ бос. Бүгдээрээ бүлгийнхээ уриаг хамт уншицгаая.

“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”

Сургаал ба Гэрээ 104:15

Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.

Унш: Сууцгаая.

Ярилц: Та сүлжээн дэх хүмүүстэйгээ холбоо тогтоосноор юу сурч мэдэж авсан бэ? Та ажилд авах шийдвэр гаргадаг менежертэй уулзсан уу? Та хэрхэн холбоо тогтоож, эргэн шалгах тухайгаа бичсэн үү? Ажил эрчимтэй хайх аргаас туршиж үзсэн хүн байна уу? Үр дүн гарсан уу?



СУРАЛЦ

БИ ШУУД СОНГОГДОХЫН ТУЛД ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?

Цаг: Суралц хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Үз: “Тэр юу мэдэхийг хүсэж байна вэ? 1-р хэсэг” (Видео бичлэг байхгүй бол 66-р хуудсыг унш.)

Ярилц: Ажил олгогчид ярилцлагын үеэр эсвэл танд өргөдлийн маягт өгөх үедээ юу мэдэхийг хүсдэг вэ? Таны хариулт шууд сонгогдоход тань тусалж чадах болов уу?

Унш: ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Би шууд сонгогдохын тулд ямар байх ёстой вэ?

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Ярилцлагын болон өргөдлийн асуултуудад сайн хариулт өгнө.

Энэ цугларалтын үеэр та бусдаас ялгарахын тулд хэрхэн ярилцлагын асуултуудад хариулах мөн өргөдөл бөглөхөд суралцах болно.



БИ ЯРИЛЦЛАГАНД ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

Унш: Бид ярилцлаганд орохоосоо айж байгаа юу? Бид ярилцлага хийж буй хүний юу асуух гэж байгааг юм уу юу мэдэхийг хүсэж байгааг ойлгохгүй байх үе байдаг уу?

Үнэн хэрэгтээ бид мэдэж *чадна*. Ихэнх ярилцлага авч байгаа хүн нийтлэг зүйл асуудаг. Бүлгээрээ ээлжлэн энэ хүснэгтийг уншицгаая.

НИЙТЛЭГ АСУУЛТУУД	ЯРИЛЦЛАГА ХИЙЖ БУЙ ХҮНИЙ МЭДЭХИЙГ ХҮСЭЖ БАЙЖ БОЛОХ ЗҮЙЛ	ХАРИУЛАХ АРГА ХЭРЭГСЛҮҮД
Та өөрийнхөө талаар ярих уу?	Тэр сайн ярьж чадах уу? Тэр бэлтгэлтэй байна уу?	“Би 30 секундэд”
Таны давуу тал юу вэ?	Түүний туршлага бидний хэрэгцээ шаардлагад тохирох уу?	Давуу талуудын тухай тодорхойлолт
Та яагаад манайд ажиллахыг хүсэж байгаа вэ?	Түүнд тодорхой зорилго бий юу?	Давуу талуудын тухай тодорхойлолт
Та өмнөх удирдлагынхаа талаар ямар бодолтой байдаг вэ?	Тэр удирдагчдаа хүндэлдэг үү?	Давуу талуудын тухай тодорхойлолт
Та хэр зэрэг ачаалал дааж ажиллах чадвартай вэ?	Тэр асуудлуудыг хэр зэрэг шийдэж чадах вэ?	Давуу талуудын тухай тодорхойлолт
Та хэр хэмжээний цалин хүсэж байгаа вэ?	Түүний хүлээлт үндэслэлтэй юу?	Асуултанд асуултаар хариул

Үз: “Тэр юу мэдэхийг хүсэж байна вэ? 2-р хэсэг” Түр зогсож, зааварчилсны дагуу оролц. (Видео бичлэг байхгүй бол 67-68-р хуудсыг унш.)

Ярилц: Ярилцлагын ямар үед “Би 30 секундэд” танилцуулга хэрэг болдог вэ? Давуу талуудын тухай тодорхойлолт хэзээ хэрэг болох вэ? Та сөрөг зүйлийг хэрхэн эерэг болгохыг харав уу?

Дадлага хий: Дараах “хурдтай дадлагыг” хийхэд зургаа юм уу долоон минут зарцуул.

- Босоод, бүлгийн нэг гишүүнд ханд.
- Та хоёрын нэг нь ажил олгогч болж, дээрх хүснэгтэн дээрх нийтлэг нэг асуултыг тавь.
- Нөгөөдөх нь ажил хайж буй хүн болж, арга хэрэгслүүдээ ашиглан асуултанд хариул.
- Дүрүүдээ солиод, үүнийг дахин хий. Нэг нэгэндээ тустай үнэлэлт дүгнэлт өг.
- Та хоёр хоёулаа ажил олгогч болон ажил хайж буй хүн болсныхоо дараа өөр хамтрагч сонго. Цаг дуустал үүнийг давтан хий.

Цугларалтын дараа гэр бүлтэйгээ эсвэл найзтайгаа үргэлжлүүлэн дадлага хий. 69-р хуудасны хүснэгтээс илүү олон асуулт хар.



БИ АСУУЛТАНД ХЭРХЭН АСУУЛТААР ХАРИУЛАХ ВЭ?

Унш: Хэрэв бид ярилцлага авч буй хүний хүсэж байгаа зүйлийг мэдэж чадахгүй бол яах вэ? Эсвэл бидэнд илүү их мэдээлэл хэрэгтэй байвал яах вэ? Заримдаа бид асуултаар хариулж чадна.

Унш: Энэ хоёр нийтлэг асуултыг харцгаая. Бид асуулт бүрийг уншаад, дараа нь баруун гар талынх нь мэдээллийг уншина.

НИЙТЛЭГ АСУУЛТУУД	ЯРИЛЦЛАГА ХИЙЖ БУЙ ХҮНИЙ МЭДЭХИЙГ ХҮСЭЖ БАЙЖ БОЛОХ ЗҮЙЛ	ХАРИУЛАХ АРГА ХЭРЭГСЛҮҮД	АСУУЛТАНД АСУУЛТААР ХАРИУЛАХ
Та ямар цалин авахыг хүсэж байна вэ?	Тэр тохиролцож чадахаар өөртөө итгэлтэй байна уу?	Асуултанд асуултаар хариул	Танайх энэ албан тушаалд ажиллах хүнд ер нь ямар цалин өгдөг вэ?
Танд ямар нэгэн асуулт байна уу?	Тэр энэ ажлыг ойлгож байна уу?	Асуултанд асуултаар хариул	Энд ажиллах хамгийн сайн давуу тал юу вэ?

Ярилц: Асуултанд асуултаар хариулах хамгийн тохиромжтой үе хэзээ вэ? Энэ нь хэзээ *тохиромжгүй* байж болох вэ? Та ярилцлагын үеэр сайн асуулт тавихад хэрхэн бэлтгэж чадах вэ?

Унш: Ярилцлагаас өмнө бид ажил олгогчийг судалж, сайн асуулт тавих бэлтгэлтэй очих ёстой. Мөн бид “Би 30 секундэд” танилцуулгад эсвэл давуу талуудын тухай тодорхойлолтдоо асуулт нэмэхээр бэлтгэж чадна. Жишээлбэл, “Та намайг өөр ямар ур чадварынхаа талаар яриасай гэж хүсэж байна?”

Сайн асуулт сайхан харилцан яриаг үүсгэж чадна.

Би танай бүтээгдэхүүнийг маш их сонирхож байна. Та нар үүнийг яаж хийдэг вэ?



Та



Ярилцлага хийж буй хүн

Таныг сонирхож байгаад би баяртай байна. Эхлээд бид түүхийг эдээ авчирдаг. Дараа нь бид . . .

Зөвлөгөө:

Хэзээ асуулт тавьж, хэзээ асуухгүй байх ёстойг сур. Асуултыг асуултаар хариулна гэдгийг хэт нухацтай хүлээж авах хэрэггүй.

Ярилцлага хийж буй хүний сэтгэл хөдлөлд мэдрэмжтэй бай. Хэт их санал зөрж зүтгэх хэрэггүй.

САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА: БИ ХЭРЭГЦЭЭНДЭЭ ТОХИРСОН АЖЛЫН ТУХАЙД ХЭРХЭН ТОХИРОЛЦООНД ХҮРЭХ ВЭ?

(ҮҮНИЙГ ЦУГЛАРАЛТЫН ҮЕЭР ХИЙХГҮЙ.)

Хэрвээ хүсвэл та энэ үйл ажиллагааг дараагийн цугларалтаас өмнө хийж болно. Ярилцлагын нэг чухал хэсэг бол тохиролцоонд хүрэх явдал юм. Та илүү ихийг мэдэхийг хүсвэл 70-72-р хуудсан дээрх “Би хэрэгцээндээ тохирсон ажлын тухайд хэрхэн тохиролцоонд хүрэх вэ?” хэсгийг унш. Гэр бүлийнхэнтэйгээ ярилц мөн дадлага хий.

МИНИЙ ХАНДЛАГА БА ГАДААД ТӨРХ ХЭР ЧУХАЛ ВЭ?

- Дадлага хий:** Хүн бүр босоод, энэ хэллэгийг гурван удаа хамт давтан хэл:
Таатай анхны сэтгэгдэл төрүүлэх ганц боломж бидэнд бий.
- Ярилц:** “Бусдаас ялгарахыг” хичээж буй таны хувьд энэ нь юу гэсэн утгатай вэ?
- Дадлага хий:** Бүлгийн нэг гишүүнтэй хамт ажиллахын тулд сандлаа ойртуул. Энэ хүснэгтийг нэг нэгэндээ уншиж өг. Хамгийн сайнаараа байхын тулд юуг сайжруулж болохоо шийд.

АМЖИЛТАНД ХҮРЭХ ЗӨВЛӨМЖ

Зан төлөв	<ul style="list-style-type: none"> • Тусламж ба амар амгаланг хүсэж залбирах • Эелдэг байж, хүндэтгэлтэй хандах • Цаг баримтлах • Компанид болон ярилцлага хийж байгаа хүнд тус компанид ажиллах сонирхолтой байгаагаа харуулах • Инээмсэглэх мөн эелдэг байх • Өөртөө итгэлтэй байх • Ойлгомжтой ярих
Гадаад төрх	<ul style="list-style-type: none"> • Нүүр, гар, хумсаа цэвэр байлгах • Нүүрний будгийг тохируулан хэрэглэх (эмэгтэйчүүд) • Үсээ даруухан маягаар засуулах • Үнэртэн хэрэглэх • Сахлаа засаж янзлах эсвэл хусах (эрэгтэйчүүд) • Мэргэжлийн хүн шиг харагдах
Хувцаслалт	<ul style="list-style-type: none"> • Цэвэрхэн хувцаслах (хувцас үнэтэй байх шаардлагагүй) • Хувцсаа индүүдэх • Ажилдаа хувцасладгаас нэг түвшин дээгүүр хувцаслах: <ul style="list-style-type: none"> ○ Хэрэв та ажилдаа жинс, футболктой явдаг бол брюкэн өмд, сорочкан цамц өмсөх ○ Хэрэв та ажилдаа сорочкан цамцтай явдаг бол цамц, зангиа зүү (эрэгтэйчүүд) эсвэл кофт өмсөх (эмэгтэйчүүд)

БИ ХЭРХЭН АЖИЛД ОРОХ ӨРГӨДӨЛ БӨГЛӨХ ВЭ?

Унш: Бид ихэнх цагаа хүмүүстэй холбоо тогтоох, ярилцлага хийхэд зарцуулахыг эрмэлздэг. Гэтэл бид цаасаар юм уу онлайнгаар өргөдөл бөглөх хэрэгтэй болдог. Өргөдөл нь цаасан дээрх ярилцлага гэсэн үг юм.

Дадлага хий: Бүлгийн хоёр гишүүнтэй хамт суу. Дараагийн хоёр хуудсан дээрх өргөдлийг бөглө. Тэгээд дараах зүйлийг уншиж, өргөдлөө хэрхэн сайжруулах талаар ярилц. Цугларалтын дараа 73-75-р хуудсыг дахин унш.

ӨРГӨДӨЛ БӨГЛӨХ ХЭСЭГ	ТЭДНИЙ ХАЙЖ БУЙ ЗҮЙЛ	АРГА ХЭРЭГСЭЛ, ЗӨВЛӨГӨӨ
Хувийн мэдээлэл	Түүнийг энэ ажилд тэнцэхгүй болгох ямар нэг зүйл (гэмт хэрэг эсвэл өөр асуудал) байна уу?	Бүх асуултанд хариул. “Би 30 секундэд” танилцуулгаа ашигла. Шударга бай, шаардлагагүй мэдээлэл бичихээс зайлсхий.
Боловсрол	Тэр энэ ажилд шаардагдах сургалтанд хамрагдсан уу?	Боломжтой бол эхлээд хамгийн дээд боловсролоо буюу сертификатаа бич. Бүх сургалт, сертификатаа тодорхой бич. Давуу талуудын тухай тодорхойлолтоо нэмж оруул.
Ажил эрхлэлтийн байдал	Түүнд бидний хайж байгаа туршлага байна уу?	Боломжтой бол эхлээд хамгийн дээд боловсролоо буюу сертификатаа бич. Ажилгүй байсан цаг хугацааг бичихээс зайлсхий эсвэл тайлбарла. Давуу талуудын тухай тодорхойлолтоо ашигла.
Лавлах хүн	Намайг тэдэнтэй холбоо барихад хүргэх хангалттай мэдээлэл энд байна уу?	Таны зан чанарыг (шударга чанар гэх мэт) батлах наад зах нь нэг хүний (зөвшөөрөл ав) мөн ажлын ур чадвар, үр дүнг батлах нэг хүний мэдээллийг бэлд.
Шагнал урамшуулал	Түүнд онцгой ур чадвар байна уу?	Хэрэв боломжтой бол хамгийн чухлаас нь эхлээд, чухал бус руу бич. Давуу талуудын тухай тодорхойлолтоо нэмж оруул.
Ерөнхий зүйл	Өргөдлийг нямбай, тодорхой бөглөсөн байна уу?	Цэвэр бич. Сайхан харагдахаар нямбай бөглө.

АЖЛЫН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Нэр: _____ Огноо: _____

Хаяг: _____

Утас: _____ Э-мэйл хаяг: _____

Албан тушаал: _____ Хүсэж буй цалин: _____ Ажиллаж эхлэх хугацаа: _____

Та энэ компанид ажиллаж байсан уу? Тийм Үгүй Огноо: _____

Хэрэв тийм бол хэзээ? _____

Та өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан уу? Тийм Үгүй Огноо: _____

Хэрэв тийм бол, тайлбарлаж бичнэ үү: _____

Боловсрол

Их сургууль: _____ Хаяг: _____

Хэдэн оноос: _____ Хэдэн он хүртэл: _____ Та сургуулиа төгссөн үү? Тийм Үгүй

Диплом: _____

Ахлах сургууль: _____ Хаяг: _____

Хэдэн оноос: _____ Хэдэн он хүртэл: _____ Та сургуулиа төгссөн үү? Тийм Үгүй

Эрдмийн зэрэг: _____

Лавлах хүн

Овог нэр: _____ Ямар холбоотой: _____ Утас: _____

Овог нэр: _____ Ямар холбоотой: _____ Утас: _____

Овог нэр: _____ Ямар холбоотой: _____ Утас: _____

Өмнө хийж байсан ажлууд

Албан тушаалын нэр: _____ Гарааны цалин: _____ Сүүлд авч байсан цалин: _____

Үүрэг хариуцлага: _____

Хэдэн оноос: _____ Хэдэн он хүртэл: _____ Ажлаас гарсан шалтгаан: _____

Компани: _____ Утас: _____

Албан тушаалын нэр: _____ Гарааны цалин: _____ Сүүлд авч байсан цалин: _____

Үүрэг хариуцлага: _____

Хэдэн оноос: _____ Хэдэн он хүртэл: _____ Ажлаас гарсан шалтгаан: _____

Компани: _____ Утас: _____

Би үнэн зөв бөгөөд бүрэн гүйцэд хариулсан болохоо баталж байна.

Өргөдөл дээр эсвэл ярилцлаганд худал, буруу ташаа мэдээлэл өгсөн бол ажилд орох шаардлага хангасан ч гэсэн ажилд орох боломжоо алдана гэдгийг би ойлгож байна.

Гарын үсэг: _____ Огноо: _____



ТУНГААН БОД

БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Цаг: Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцахыг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

Ярилц: Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

“Би чиний явах ёстой замд чамд зааварлан зааж өгнө. Би чамайг ширтэн, чамд зөвлөнө.”

ДУУЛАЛ 32:8





АМЛАЛТ ӨГ

БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

Цаг: Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

Хамтрагчийн нэр

Холбоо барих мэдээлэл

Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.

МИНИЙ АМЛАЛТУУД

Би өөрийнхөө таньдаг хүмүүсээс болон тэдний танилуудаас (миний сүлжээ) наад зах нь 40 хүнд “Би 30 секундэд” танилцуулга болон давуу талуудын тухай тодорхойлолтоо хэлэх болно.

Зорилгоо дугуйл: 40 50 60

Би таньдаг хүмүүстэйгээ болон менежертэй уулзахыг хичээж, наад зах нь 10 боломжит ажил олгогчтой нүүр тулж уулзахыг хичээнэ.

Зорилгоо дугуйл: 10 15 20

Би ярилцлага хийх, өргөдөл бөглөх чадваруудаараа ажил олгогчтой болон бусадтай дадлага хийнэ.

Би өнөөдрийн “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

Миний гарын үсэг

Хамтрагчийн гарын үсэг

БИ ГАРГАЖ БУЙ АХИЦАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

Дадлага хий: Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх зайд “Тийм”, “Үгүй” гэж, эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Наад зах нь 40 хүнтэй холбоо барьсан (Тоог бич)	Наад зах нь 10 боломжит ажил олгогчтой уулзсан (Тоог бич)	Би ярилцлага хийх, өргөдөл бөглөх чадваруудаар дадлага хийсэн. (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

Унш: Түүнчлэн “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлынхоо арын хуудсан дээр зарлагаа тэмдэглээрэй.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” дээрх сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. (“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 13-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа srsfeedback@ldschurch.org хаягаар илгээнэ үү.

Эх сурвалж

“ТЭР ЮУ МЭДЭХИЙГ ХҮСЭЖ БАЙНА ВЭ? 1-Р ХЭСЭГ

Дүрээ сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

ҮЙЛ ЯВДЛЫН ЭХЛЭЛ: *Хосе (дарга)*
Мигуэлтэй (ажил хайгч) ярилцлага хийж байна. Энэ үйл явдал ярилцлагын дундуур болжээ.

ХОСЕ: *За, сайн байна. Чи хамгийн сүүлд гаргасан том алдаагаа, мөн энэ нь яагаад гарсныг болон энэ талаар юу хийснээ ярьж болох уу?*

МИГУЭЛ: *[Бодож байна] Энэ ямар учиртай асуулт вэ? Тэр юу хүсэж байна вэ? Түүний юу хайж байгааг мэдээд авах юмсан.*

ХОСЕ: *[Бодож байна] Би түүнийг юуг буруу хийснээ ойлгож байгаа эсэхийг мөн гарсан асуудлыг зассан эсэхийг нь мэдмээр байна.*

МИГУЭЛ: *[Бодож байна] Түүний юу хайж байгааг мэдээд авах юмсан. Би сөрөг зүйлийг эерэг болгож хувиргах хэрэгтэй юм байна.*

МИГУЭЛ: *[Чангаар] Нэг удаа менежер маань намайг ажлаа товлосон хугацаанаас хоцроосон гэж бодож байсныг санаж байна. Би харилцагчийнхаа гаргасан зарим өөрчлөлтийг сайн хэлж ойлгуулж чадаагүй учраас ийм зүйл гарсан юм л даа. Үүнээс хойш би юу болж байгааг хүн бүрд хэлдэг болсон.*

ХОСЕ: *Энэ дажгүй сонсогдож байна шүү, Мигуэл. Чи ямар нэг зүйл сурч мэдсэн юм шиг сонсогдож байна.*

56-р хуудас руу буцаж оч

“ТЭР ЮУ МЭДЭХИЙГ ХҮСЭЖ БАЙНА ВЭ? 2-Р ХЭСЭГ

Дүрээ сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл. Зохицуулагчийн анхааралд: Ярилц гэж зөвлөсөн үед цааш үргэлжлүүлэхээсээ өмнө бүлгийн гишүүдэд хариулах боломж олго.

ӨГҮҮЛЭГЧ: Бид одоо Хосе (ярилцлага авч буй), Мигуэл (боломжит ажилтан) хоёрын ярилцлагыг үзэх болно. Хосе нийтлэг дөрвөн асуулт тавина. Мигуэл хэрхэн

хариулах ёстой талаар бид ярилцах болно. Та нар бэлэн үү?

ХОСЕ: Сайн байна уу? Та өөрийнхөө талаар юу хэлж чадах вэ?

ЯРИЛЦ: (1) Ярилцлага хийж буй хүн юу мэдэхийг хүсэж байна вэ? (2) Мигуэл хариулахын тулд “Би 30 секундэд” танилцуулгыг хэрхэн ашиглаж болох вэ? (Баруун гар талд байгаа загварыг хар.)

ӨГҮҮЛЭГЧ: Уг даргын юу бодож байгааг доор харуулав.

ХОСЕ: Тэр тодорхой хариулт өгч чадах уу? Тэр энэ ажилд тэнцэх үү?

ӨГҮҮЛЭГЧ: Мигуэл “би 30 секундэд” танилцуулгаа ашиглах хэрэгтэй байх.

МИГУЭЛ: Намайг Мигуэл Фүэнтэс гэдэг. Би танай шинэ нягтлан бодох бүртгэлийн менежерийн ажилд өргөдөл өгч

байгаа. Би зургаан жил ажилласан туршлагатай ба таван хүнтэй нягтлан бодох багийг удирдаж байсан. Өнгөрсөн жил бид хамтдаа зардлыг 15 хувиар бууруулж, бүтээмжийг 23 хувиар нэмэгдүүлсэн. Би нягтлан бодох бүртгэлийн сертификаттай төгссөн бөгөөд засгийн газрын үнэмлэхтэй. Амралтын өдрүүдэд би хөл бөмбөгийн тоглолт үзэх дуртай. Та өөр юу мэдэхийг хүсэж байна вэ?

ХОСЕ: Энэ хангалттай, баярлалаа. Танд өөр ямар ямар давуу тал байдаг вэ?

ЯРИЛЦ: (1) Ярилцлага хийж буй хүн юу мэдэхийг хүсэж байна вэ? (2) Мигуэл хариулахын тулд давуу талуудын тухай тодорхойлолтоо хэрхэн ашиглаж болох вэ? (Баруун гар талд байгаа загварыг хар.)

ӨГҮҮЛЭГЧ: Энэ бол Хосегийн сонсохыг хүсэж буй зүйлүүд.

ХОСЕ: Бидэнд хэрэгтэй байгаа ур чадвар түүнд байна уу? Тэр үр дүн гаргаж, ур чадвараа нотолж чадах уу?

ӨГҮҮЛЭГЧ: Хосе үүнийг хүсэж байгаа учраас Мигуэл хариулахын тулд давуу талуудын тухай тодорхойлолтоо ашиглаж магадгүй.

МИГУЭЛ: Би нэг жишээ хуваалцъя. Би үргэлж зардал бууруулах арга зам эрж хайдаг. Жишээлбэл: Гурван сарын өмнө би

менежертэйгээ уулзаад, хугацаа хэтэрсэн төлбөр хийснээс болж бид долоо хоног бүр 3000 доллар алдаж байгааг тайлбарлаж өгсөн. Тэр эхлээд эргэлзэж байсан ч би түүнд тоо баримт үзүүлсэн. Тэгээд тэр асуудлыг шийдэхийг надаас хүссэн. 10 долоо хоногийн дотор би хугацаа хэтэрсэн төлбөрүүдийг 30 хувиар бууруулсан бөгөөд хэдэн мянган доллар хэмнэж чадсан. Би асуудал шийдвэрлэх энэ чадвараа ашиглаад, Спорт корпорацид тусалж чадна.

“Би 30 секундэнд”

1. Нэр
2. Зорилго
3. Ур чадвар
4. Зан чанар
5. Асуултаар төгсгө

Давуу талуудын тухай тодорхойлолт

1. Ур чадвар эсвэл давуу талаа тодорхойл
2. Тодорхой жишээ ав
3. Үр дүнг хэл
4. Хэрэгцээ шаардлагад тохируул

ӨГҮҮЛЭГЧ: Бидний сонсох дургүй нэг асуулт энд байна.

ХОСЕ: Танд ямар сул тал байдаг вэ?

ЯРИЛЦ: (1) Ярилцлага хийж буй хүн юу мэдэхийг хүсэж байна вэ? (2) Мигуэл хэрхэн сөрөг зүйлийг эерэг болгож харнулж чадах вэ? (Баруун гар талд байгаа загварыг хар.)

ӨГҮҮЛЭГЧ: Энэ үед ярилцлага хийж буй хүн дараах зүйлийг бодож байна.

ХОСЕ: Тэр ямар нэг сул талаа мэдэж байна уу? Тэр үүнийг ялахын тулд ямар нэг зүйл хийсэн үү?

ӨГҮҮЛЭГЧ: Хосе ийм зүйл сонсохыг хүсэж байгаа учраас Мигуэл сөрөг зүйлийг эерэг болгосон хариулт өгч болно.

МИГУЭЛ: Намайг нэхэмжлэлээ цагт нь төлөхөд харилцагчдад туслах тал

дээр хэт их санаа тавьдаг гэж зарим хүн хэлдэг. Тиймээс би төлбөрийн үр дүн, харилцагчийн үйлчилгээг тэнцвэртэй байлгахын тулд шаргуу ажилласан. Би маш их зүйл сурсан. Би бүх харилцагчдаа болон тэдний хэрэгцээнд санаа тавьснаар төлбөрөө хурдан авахад нь компанидаа тусалж чадсан. Өнгөрсөн сард би харилцагчдад ишлдэг үйлчилгээ үзүүлсэн ажилтнаар шалгарсан.

ӨГҮҮЛЭГЧ: За одоо сүүлчийн нийтлэг асуултыг харцгаая.

ХОСЕ: Сайн байна, Мигуэл. Баярлалаа. Тэгвэл та яагаад манайд ажиллахыг хүсэж байна вэ?

ЯРИЛЦ: (1) Ярилцлага хийж буй хүн юу мэдэхийг хүсэж байна вэ? (2) Мигуэл хариулахын тулд давуу талуудын тухай тодорхойлолтоо хэрхэн ашиглаж болох вэ? (Баруун гар талд байгаа загварыг хар.)

ӨГҮҮЛЭГЧ: Энэ үед ярилцлага хийж буй хүн дараах зүйлийг бодож байна.

ХОСЕ: Бидэнд юу хэрэгтэй байгааг тэр мэдэж байна уу? Энэ нь түүнд хамаатай юу?

ӨГҮҮЛЭГЧ: Ярилцлага хийж буй хүн ийм зүйл сонсохыг хүсэж байгаа учраас Мигуэл өөр нэг давуу талын тухай тодорхойлолтоо ашиглан хариулт өгч болно.

МИГУЭЛ: Ноён Мартинез, Спорт корпорацийн талаар хийсэн судалгаа маань маш их сонирхолтой байсан. Танайх спортын тоног төхөөрөмжийн худалдаанд төвлөрч, энэ тал дээр амжилттай

ажилласаар ирсэн юм байна. Та нар шинэ, сайжруулсан бүтээгдэхүүн гаргах гэж байгааг би сонссон. Би өсөж буй амжилттай компанид ажиллахыг хүсэж байна. Би бас биеийн тамир, дасгал хөдөлгөөний талаар бага зэрэг мэднэ. Өнгөрсөн жил би сайн дураараа хөл бөмбөгийн дасгалжуулагч хийсэн бөгөөд багийн гишүүдэд тэсвэр тэвчээртэй байж, гүйцэтгэлээ сайжруулахад нь тусалсан. Би таны юу хийхийг хүсэж байгааг ойлгож байгаа бөгөөд үүнийг хийхэд танд тусалж чадна.

57-р хуудас руу буцаж оч

Сөрөг зүйлүүдийг эерэг болго.

1. Олон хүнд байдаг нийтлэг сул талаа хэл.
2. Энэ сул талаа хэрхэн ялан дийлсэн тухайга тодорхой ярь.
3. Давуу талуудын тухай тодорхойлолтоосоо мэдээлэл нэмж оруул.

Давуу талуудын тухай тодорхойлолт

1. Ур чадвар эсвэл давуу талаа тодорхойл
2. Тодорхой жишээ ав
3. Үр дүнг хэл
4. Хэрэгцээ шаардлагад тохируул

НИЙТЛЭГ АСУУЛТУУДАД ХАРИУЛАХ ДАДЛАГА ХИЙ

Дараагийн цугларалтаас өмнө хамтрагчтайгаа болон гэр бүлтэйгээ эсвэл найзтайгаа асуултанд хариулах дадлага хий.

НИЙТЛЭГ АСУУЛТУУД	ЯРИЛЦЛАГА ХИЙЖ БУЙ ХҮНИЙ МЭДЭХИЙГ ХҮСЭЖ БАЙЖ БОЛОХ ЗҮЙЛ	ХАРИУЛАХ АРГА ХЭРЭГСЛҮҮД
Та өөрийнхөө талаар ярих уу?	Тэр сайн ярьж чадах уу? Тэр энэ ажилд тэнцэх үү?	“Би 30 секундэд”
Таны давуу тал юу вэ?	Түүний туршлага бидний хэрэгцээ шаардлагад тохирох уу?	Давуу талуудын тухай тодорхойлолт
Таны сул тал юу вэ?	Тэр шударга уу? Тэр сайжирсан уу?	Сөрөг зүйлийг эерэг болго
Та яагаад манайд ажиллахыг хүсэж байгаа вэ?	Тэр судалгаа хийсэн үү? Түүнд зорилго бий юу?	Давуу талуудын тухай тодорхойлолт
Хамгийн сүүлд гаргасан том алдааныхаа тухай ярь.	Түүний алдсан шалтгаан нь зөвтгөж болохоор байна уу? Тэр үүнээс юу сурч мэдсэн бэ?	Сөрөг зүйлийг эерэг болго
Та өмнөх даргынхаа талаар ямар бодолтой байдаг вэ?	Тэр удирдагчдаа хүндэлдэг үү?	Давуу талуудын тухай тодорхойлолт
Та хэр зэрэг ачаалал дааж ажиллах чадвартай вэ?	Тэр асуудлуудыг хэр зэрэг шийдэж чадах вэ?	Давуу талуудын тухай тодорхойлолт
Таны саналыг хүлээн аваагүй тохиолдол байсан уу?	Тэр шаргуу зүтгэдэг үү? Тэр эерэг хандлагатай юу?	Сөрөг зүйлийг эерэг болго
Таны ажил мэргэжлийн зорилго юу вэ?	Тэр биднийг амжилтанд хүрэхэд туслах уу? Тэр ажилдаа төвлөрч чаддаг уу?	“Би 30 секундэд”
Та хэр хэмжээний цалин хүсэж байгаа вэ?	Түүний хүлээлт үндэслэлтэй юу?	Асуултанд асуултаар хариул
Танд ямар нэгэн асуулт байна уу?	Тэр санаа тавьдаг уу? Тэр ажил хийх сонирхолтой байгаа юу?	Асуултанд асуултаар хариул

БИ ХЭРЭГЦЭЭНД МИНЬ НИЙЦЭЖ БУЙ АЖЛЫН ТАЛААР ХЭРХЭН ТОХИРОЛЦООНД ХҮРЭХ ВЭ? (САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА)

Унш: Ажил олгогч биднийг ажилд авах шийдвэр гаргах үед бид ажлын нөхцөлөө ярилцах хэрэгтэй болно. Эдгээр нөхцөл нь бидний цалинг болон хэзээ бас хэр удаан ажиллахыг, мөн ажлын байрны нөхцөл байдал юм уу өөр зүйлүүдийг багтаадаг. Үүний зорилго нь нээлттэй, шударга байж, хүн бүр сэтгэл хангалуун байх ёстойд оршино.

Ярилц: Харилцан тохиролцоонд хүрэхэд юу нь хэцүү вэ? Яагаад харилцан тохиролцоо шаардлагатай вэ?

Унш: Энэ төрлийн ярилцлаганд бэлтгэхийн тулд таны хийж болох таван алхмыг энд оруулав.

- Хэрэгцээгээ урьдчилан тодорхойлох
- Хамгийн чухал болон хүлээн зөвшөөрч болохуйц хамгийн доод нөхцөлүүд юу вэ гэдгийг тодорхойлох
- Ажил олгогч ямар санал тавьж болохыг мөн тэдэнд юу чухал болохыг олж мэдэх
- Илчлэлт эрэлхийлж, ажил олгогчид болон бидэнд “ашигтай” байх арга замуудыг бодох
- Гэр бүлийнхээ гишүүн юм уу найзтайгаа ярилцлага хийх дадлага хийх

Дадлага хий: Ажилтай холбоотой хэрэгцээнийхээ талаар бодохын тулд дараах хүснэгтийг ашигла.

Жишээнүүд саарал өнгөөр бичигдсэн бөгөөд дээр нь бич.

1. Хэрэгцээ бүрийг өөртөө хамгийн чухлаас эхлэн дараалалд оруул. Хамгийн чухал хэрэгцээг “1” гэж тэмдэглэ.
2. Хэрэгцээ бүрийн хамгийн доод түвшин юу болохыг шийд.
3. Эдгээрийг ханьтайгаа эсвэл гэр бүлийнхэнтэйгээ ярилц. Тэднээс хамгийн чухал хэрэгцээгээ бичихийг хүсээд, хамгийн бага түвшингүүдийг хамтдаа тодорхойл. Хоорондоо зөрж байвал хамтдаа зөвшилцөлд хүр.

МИНИЙ ХЭРЭГЦЭЭ (Нэмж бич)	МИНИЙ ЭН ТЭРГҮҮНД ТАВИХ ЗҮЙЛҮҮД (тус бүрийг дугаарла, 1 бол хамгийн чухал нь)	ГЭР БҮЛИЙН ЭН ТЭРГҮҮНД ТАВИХ ЗҮЙЛҮҮД (тус бүрийг дугаарла, 1 бол хамгийн чухал нь)	ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БОЛОХУЙЦ ХАМГИЙН ДООД НӨХЦӨЛ (хэрэгцээ бүрийн доод хязгаар)	АЖИЛ ОЛГОГЧИЙН ЭН ТЭРГҮҮНД ТАВИХ ЗҮЙЛҮҮД (тэдний хүсэл/хэрэгцээ хамгийн чухлаасаа эхэлнэ)
Цалин	1	2	сард 3000	Цалингийн хязгаар 2200-3200
Ажлын цаг	5	1	Ням гарагт амарна	Шаардлагатай бол амралтын өдрүүдэд ажиллана
Цэвэр орчин	6	5	Аюултай химийн бодис байхгүй	Ажил хурдасгах химийн бодис
Хамт ажиллагчид	3	6	Шударга	Нягт нямбай, ажилсаг
Боломж	2	4	90 өдрийн дараа албан тушаал дэвших өдөр	Багаар ажилладаг
Эрүүл мэндэд тавих анхаарал	4	3	-----	

Ярилц: Та нар энэ дасгалаас юу сурч мэдсэн бэ?

Дадлага хий: Хамт ажиллахыг хүсэж буй ажил олгогчийн талаар бод. Тэд юуг эн тэргүүнд тавьдаг вэ? Тэдэнд юу хамгийн чухал вэ гэдгийг та олж мэдэж чадах уу? Ярилцлаганд орохоосоо өмнө ажил олгогчийнхоо эн тэргүүний хэрэгцээг дээрх хүснэгтэд бич.

Ярилц: Туршлага дээрээ тулгуурлан, та хэрхэн өөрийнхөө хэрэгцээг ажил олгогчийн хүсэлтэй нийцүүлж чадах вэ?

Дадлага хий: Гэр бүлийн гишүүнтэйгээ эсвэл найзтайгаа энэ жүжигчилсэн тоглолтыг хий.

1. Энэ нөхцөл байдлын талаар унш: Эхний ярилцлаган дээрээ Кофи энэ албан тушаалын цалингийн хязгаар нь өдрийн 95-105 гэдгийг мэдэж авчээ. Одоо тэр хоёр дахь ярилцлагандаа орж байна. Ажил олгогч өдрийн 96-г түүнд санал болгов. Наад зах нь боломжит 100 ажил олгогчтой уулзсан. Түүнд тээврийн хэрэгслээр зорчих мөнгө бас хэрэгтэй бөгөөд ням гарагт ажиллахгүй байхаар шийджээ.
2. Нэг нь ажил олгогч, нөгөөх нь Кофигийн дүрд тогло. Ажил олгогч эхлээд өдрийн 96-г Кофид санал болгоно. Тэр түүнээс сард хоёр ням гарагт ажиллахыг хүсжээ. Кофи хоёр талд ашигтай байдлаар харилцан тохиролцоо ёстой.
3. Дараа нь дүрээ солиод, үүнийг дахин хий.

Ярилц: Энэ ямар байсан бэ? Та асуултанд асуултаар хариулсан уу? Та өөр ашигтай зүйлүүдийн талаар тохиролцоо тухай бодсон уу?

Унш: Кофигийн тохиролцоо ямар байж болох нэг жишээг энд харуулав. Энэ хүснэгтэн дээрх мэдээллийг хамт уншицгаая. Хэн ялсан бэ? Тэд ням гарагт ажиллах эсэхийг шийдвэрлэсэн үү?

Зөвлөгөө:

Хэрэв санал болгож буй цалин хэт бага байвал чимээгүй байхыг хичээ. Хариулахаасаа өмнө 10 секунд хүлээ. Дуугүй болох үед чинь тантай тохиролцож буй хүн ихэвчлэн илүү өндөр цалин санал болгодог.

АНХНЫ САНАЛ	КОМПАНИД ЧУХАЛ	КОФИД ЧУХАЛ	КОФИГИЙН ТОХИРОЛЦОО	ШИНЭЧИЛСЭН САНАЛ
Өдрийн 96-г авах	Компани Кофигийн түвшний туршлагатай хүнийг өдрийн 98-аар цалинжуулж чадна.	Кофид өдрийн 100 хэрэгтэй. 100-аас 3 нь ажил руугаа явах унаанд зарцуулагдана.	Кофи компаниас өдрийн 97-г, дээр нь автобусны зардал болох өдрийн 3-ыг авахыг хүсэв.	Компани Кофид өдрийн 97-г өгч, дээр нь автобусны зардал өгөхөөр тохирчээ. Компани автобусны компанитай гэрээтэй. Тиймээс Кофигийн зардалд өдрийн 1-ийг л төлөх юм.

Ярилц: Хэрэв та тохиролцоонд хүрч чадахгүй бол яах вэ? Хэрэв энэ санал таны хэрэгцээнд нийцэхгүй байвал та үүнээс татгалзах ёстой юу?

Унш: Та харилцан тохиролцоо чадвараар дадлага хийснээр, оролцож буй хүн бүрд ашигтай тохиролцоонд хүрч чадна. Та ямар ч тохиролцоонд хүрсэн бай, баталгаажуулсан баримтыг огноотой нь хамт бичгээр авч бай. Энэ нь хүн бүрийг хамгаалах болно!

АЖЛЫН ӨРГӨДЛИЙН ЖИШЭЭ

АЖЛЫН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Нэр: Пулмагари Амит Огноо: 2013 оны 12-р сарын 6
Овог Нэр

Хаяг: 1234 Эни гудамж, Хайдарабад

Утас: 1234567890 Э-мэйл хаяг: Amit1234@emailcompany.com

Албан тушаал: Үйл явцын сургагч Хүсэж буй цалин: 70000 Ажиллаж эхлэх хугацаа: 2014 оны нэгдүгээр сар

Та энэ компанид ажиллаж байсан уу? Тийм Үгүй Огноо: _____

Хэрэв тийм бол хэзээ? _____

Та өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан уу? Тийм Үгүй Огноо: _____

Хэрэв тийм бол тайлбарлаж бичнэ үү: _____

Боловсрол

Их сургууль: Эни Техникийн коллеж Хаяг: 4321 Эни гудамж, Гангток

Хэдэн оноос: 2011 Хэдэн он хүртэл: 2013 Та сургуулиа төгссөн үү? Тийм Үгүй

Диплом: Гэрчилгээ

Ахлах сургууль: Эни дунд сургууль Хаяг: 1234 Эни гудамж, Хайдарабад

Хэдэн оноос: 2002 Хэдэн он хүртэл: 2007 Та сургуулиа төгссөн үү? Тийм Үгүй

Эрдмийн зэрэг: Гэрчилгээ

Лавлах хүн

Овог нэр: Вивэк Синг Ямар холбоотой: Багш Утас: 1234567891

Овог нэр: Шрати Патэл Ямар холбоотой: Дарга Утас: 1234567892

Овог нэр: Кавита Рам Ямар холбоотой: Хамтран ажиллагч Утас: 1234567893

Өмнө хийж байсан ажлууд

Албан тушаалын нэр: Зохицуулагч Гарааны цалин: 40000 Сүүлд авч байсан цалин: 45000

Үүрэг хариуцлага: Угсралтын хэсгийн ажиллагчдыг удирдах

Хэдэн оноос: 2010 Хэдэн он хүртэл: 2011 Ажлаас гарсан шалтгаан: Сургуульд дахин сурсан

Компани: Эни компани Утас: 1234567894

Албан тушаалын нэр: Ажлын сургагч Гарааны цалин: 30000 Сүүлд авч байсан цалин: 32000

Үүрэг хариуцлага: Ажиллагчдыг сургах

Хэдэн оноос: 2008 Хэдэн он хүртэл: 2010 Ажлаас гарсан шалтгаан: Шинэ ажил

Компани: Анодэр компани Утас: 1234567895

Би үнэн зөв бөгөөд бүрэн гүйцэд хариулсан болохоо баталж байна.

Өргөдөл дээр эсвэл ярилцлаганд худал, буруу ташаа мэдээлэл өгсөн бол ажилд орох шаардлага хангасан ч гэсэн ажилд орох боломжоо алдана гэдгийг би ойлгож байна.

Гарын үсэг: Амит Пулмагари Огноо: 2013 оны 12-р сарын 6

ТОВЧ НАМТРЫН ЖИШЭЭ

Виллям Овусу

Хаяг: 1234 Эни гудамж, Аккра, Гана

Утас: 1234567896

Э-мэйл: owusu1234@emailcompany.com

Хувийн мэдээлэл

Овог нэр	Виллям Овусу
Хүйс	Эрэгтэй
Төрсөн огноо	1980 оны 4-р сарын 16
Төрсөн газар	Гана, Кумаси
Гэр бүлийн байдал	Ганц бие

Боловсрол

2007-2011	Эни Техникийн сургуулийг сертификаттай төгссөн
2000	Эни ахлах сургуулийг төгссөн

Ажлын дадлага туршлага

2004–2006	Бүрэн цагийн номлогчоор үйлчилсэн
2007-2011	Эни ресторанд багийн удирдагчаар ажилласан
2011–	Эни Лимузин компанид захиалгын ажилтнаар ажиллаж байна

Хамрагдсан сургалт

2009	Хүснэгтэн тооцоолол хийх дамжааг дүүргэсэн
2013	Харилцагчийн үйлчилгээний сургалтыг дүүргэсэн
2012	Жижиг бизнесийн сургалтыг дүүргэсэн

Компьютер дээр ажиллах чадвар

2003	Хүснэгтэн тооцоолол, мэдээллийн сан, интернэт/э-мэйл
------	--

Эзэмшсэн хэл

Ашанти тви	Төрөлх хэл
Англи хэл	Сайн

Сонирхол, хобби

Ном унших, спорт тоглоом тоглох, интернэт

Лавлах хүмүүс

1. Сандра Осэй	Утас: 1234567897
2. Эрик Катока	Утас: 1234567898



5

*Би хэрхэн ажил
эрчимтэй хайх вэ?*

Ажил хайх нь

ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд.

Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Энэ амлалтын хүснэгтийг самбар дээр зур.

Бүлгийн гишүүний нэр	Наад зах нь 40 хүнтэй холбоо барьсан (Тоог бич)	Наад зах нь 10 боломжит ажил олгогчтой уулзсан (Тоог бич)	Би ярилцлага хийх, өргөдөл бөглөх чадваруудаар дадлага хийсэн. (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамт-рагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глорця	52	14	T	T	T	T

Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч угт.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

Цугларалт эхлэх үед:

- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирлаар эхэл (хүсвэл дуулал дуулж болно).
- Хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 5-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.



ТАЙЛАГНА

БИ АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

Цаг: Тайлагна хэсэгт 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Алга таш.)

Унш: Одоо бүгдээрээ бос. Бүгдээрээ бүлгийнхээ уриаг хамт уншицгаая.

“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”

Сургаал ба Гэрээ 104:15

Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.

Унш: Сууцгаая.

Ярилц: Та ярилцлагын үеэр асуудаг түгээмэл асуултуудад сайн хариулт өгөх талаар дадлага хийсэн үү? Хэн нэгэн тэдгээрийг ярилцлагандаа ашигласан уу?

Та харилцан тохиролцох талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцах үедээ юу сурч мэдсэн бэ? Та тохиролцох талаар дадлага хийсэн үү? Танд санаа зовж байгаа зүйл байна уу?



СУРАЛЦ

БИ ХЭРХЭН АЖИЛ ЭРЧИМТЭЙ ХАЙХ ВЭ?

Цаг: Суралц хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Унш: Бид ажил хайхад маань туслах хэдэн чухал арга хэрэгсэлтэй боллоо:

- “Би 30 секундэд”
- Давуу талуудын тухай тодорхойлолт
- Сөрөг зүйлийг эерэг болго
- Асуултанд асуултаар хариулах
- Ярилцлагын үеэр асуудаг нийтлэг асуултаудад хариулах
- Өргөдөл бөглөх
- Гадаад төрх ба зан харьцаагаа сайжруулах

Энэ цугларалтын үеэр бид ажил хайхаа эрчимжүүлэхийн тулд эдгээр аргыг хэрхэн ашиглахад суралцах болно.

Ярилц: Энэ бүх арга таныг ажил хайхад тусална гэж бодоход танд ямар санагдаж байна вэ?

Унш: ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Би хэрхэн ажил хайхаа эрчимжүүлэх вэ?

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Эх сурвалж, танил тал болон нүүр тулсан уулзалтынхаа тоог эрс нэмэгдүүлнэ.

Манай бүлгийн зарим хүн ажил эрчимтэй хайж байж магадгүй. Энэ цугларалт дээр бид бүгд ажил хайхаа эрчимжүүлэх болно.

ӨДӨР БҮР АЖИЛ ХАЙХ НЬ

Унш: Одоо бид энэ бүх аргаа ашиглах, мөн ажилд орохоо эрчимжүүлэх цаг боллоо.

Үз: “Рафаэл: 6 өдрийн дотор ажилд оров” (Видео бичлэг байхгүй бол 88-р хуудаснаас “Өдөр бүр ажил хайх нь: Албагийн түүх”-ийг унш.)

Ярилц: Ажил эрчимтэй хайхаа амжилттай болгоход Рафаэлд эсвэл Албад юу тусалсан бэ?

Дадлага хий: Ажил эрчимтэй хайх нь өдөр тутам ажил хайх үр дүнтэй стратеги юм. Зарим газарт энэ арга нь ажил олох хугацааг 200 хоногоос 20 хоног хүртэл багасгаж чадсан! Үүнд өдөрт ойролцоогоор хоёроос дөрвөн цаг зарцуулагдах болно. Энэ нь өдөр тутам хийх гурван үйл ажиллагааг багтаадаг:

1. 15 шинэ эх сурвалж тодорхойл.
2. Эдгээр эх сурвалжаас 10 хүнтэй холбоо тогтоо.
3. Холбоо тогтоосон хүмүүсээс наад зах нь 2 хүнтэй нүүр тулсан уулзалт эсвэл ярилцлага хий.

Үз: “Өдөр тутам ажил хайх нь: Эх сурвалж” (Видео бичлэг байхгүй бол 88-р хуудсыг унш.)

Дадлага хий: Яг одоо дараагийн хуудсан дээр байгаа хүснэгтэн дээр санаанд орсон аль болох олон эх сурвалжаа эхний баганд бичиж эхэл. Эдгээр нь танд тустай мэдээлэл бүхий хүмүүс ба газар, зүйлүүд юм! Зарим жишээг оруулав. 91-р хуудсан дээрх маягтыг ашиглан, дараагийн цугларалтаас өмнө илүү олон маягт бөглө. Эх сурвалж гэсэн жагсаалтан дээрээ үргэлжлүүлэн нэмэхдээ хоосон маягтыг хувиалан гарга.

Үз: “Өдөр тутам ажил хайх нь: Эх сурвалж” (Видео бичлэг байхгүй бол 89-р хуудсыг унш.)

Дадлага хий: Одоо дараагийн хуудсан дээр дараагийн цугларалтаас өмнө холбоо тогтоох боломжтой аль болох олон хүний нэрийг жагсаан бич. Санаа зовох хэрэггүй гэдгийг сана. Өдөрт 10 хүнтэй холбоо тогтоох арга замыг хайж ол!

Үз: “Өдөр тутам ажил хайх нь: Уулзалтууд” (Видео бичлэг байхгүй бол 89-р хуудсыг унш.)

Унш: Одоо дараагийн хуудсан дээр дараагийн цугларалтаас өмнө нүүр тулан уулзаж болох аль болох олон хүний нэрийг жагсаан бич. Тэдэнтэй хэзээ, хаана уулзахаа бод. Уулзалт бүр дээр “Би 30 секундэд” танилцуулгаа ашиглахаа битгий мартаарай.

Үз: “Өдөр тутам ажил хайх нь: Бүгдийг хамтад нь ашиглах нь” (Видео бичлэг байхгүй бол 90-р хуудсыг унш.)

Дадлага хий: Одоо дараагийн хуудсан дээрх хүснэгтийг хар. Та нэгдүгээрт, хоёрдугаарт, гуравдугаарт юу хийх вэ? Эх сурвалж олж, холбоо тогтоон, өдөр бүр нүүр тулсан уулзалт хийх төлөвлөгөө гарга. Үүнийг хэзээ хийхээ шийдээд, гэр бүлийнхнээсээ эсвэл хамтрагчаасаа тусламж хүс. Их Эзэнээс удирдамж хүсэн залбир.

ЭХ СУРВАЛЖ, ХОЛБОО ТОГТООХ ХҮМҮҮС БА УУЛЗАЛТУУДЫН МАЯГТ

ЭХ СУРВАЛЖ (жагсаалт гарга)	ТАНИЛЫН ХЭЛХЭЭ ХОЛБОО ТОГТООХ (утас, э-мэйл)	УУЛЗАЛТ (нүүр тулсан)
Интернэт сайтууд	Чуулгын эсвэл Халамжийн Нийгэмлэ- гийн гишүүд	Боломжит ажил олгогчид
Сонинууд	Тантай хамт ажилладаг байсан хүмүүс	Гэрийн багш нар
Ажилд зуучлах үйлчилгээ	Багш нар	Сүмийн гишүүд
Бие даах чадвар хөгжүүлэх төв	Дэлгүүрт тааралдсан хүмүүс	

АЖИЛ ЭРЧИМТЭЙ ХАЙХ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Унш: Энд ажил эрчимтэй хайх бүртгэлийн маягтыг харуулав. 92-р хуудсан дээрх хүснэгтэнд эх сурвалж, холбоо тогтоох хүмүүс ба хийсэн уулзалтуудаа бүртгэ. Олон долоо хоног хэрэглэхэд хүрэлцэх тоогоор хуулбар хий.

(Нүднүүдэд хэрээс тавь мөн тэмдэглэл нэм. Нийт өдрийн тоог үзүүл.)

1 ДЭХ ӨДӨР

Эх сурвалж: Нийт өдрийн тоо 15

Холбоо тогтоосон: Нийт өдрийн тоо 10

Ярилцлага: Нийт өдрийн тоо 2

Тэмдэглэл:

Кассчны ажилд хүн авчихсан гэсэн. Тэд зах дээр очоод үз гэж хэлсэн. Тэнд ажилд авч байж магадгүй.

2 ДАХЬ ӨДӨР

Эх сурвалж: Нийт өдрийн тоо 15

Холбоо тогтоосон: Нийт өдрийн тоо 8

Ярилцлага: Нийт өдрийн тоо 2

Тэмдэглэл:

Хосе өнөөдөр уулзаж чадаагүй. Тэр нүрэв гарагт эргэж ирээрэй гэсэн.

3 ДАХЬ ӨДӨР

Эх сурвалж: Нийт өдрийн тоо 14

Холбоо тогтоосон: Нийт өдрийн тоо 10

Ярилцлага: Нийт өдрийн тоо 3

Тэмдэглэл:

Зах дээр Мариагаас авсан ажилд орох өргөдлийг бөглө.



ТУНГААН БОД

БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Цаг: Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцахыг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

Ярилц: Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

*“Хичээнгүйлэн судлаг-
тун, үргэлж залби-
рагтун, мөн итгэлтэй
байгтун, мөн хэрэв
та нар цэх шулуун
алхаж . . . аваас, мөн
та нарын сайн сайхны
тулд бүх зүйл хамтдаа
ажиллах болно.”*

СУРГААЛ БА ГЭРЭЭ 90:24



АМЛАЛТ ӨГ

БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

Цаг: Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

Хамтрагчийн нэр

Холбоо барих мэдээлэл

Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.

МИНИЙ АМЛАЛТУУД

Би өдөрт наад зах нь 15 шинэ эх сурвалж тодорхойлно (долоо хоногт наад зах нь 75).

Зорилгоо дугуйл: 75 80 85

Би өдөрт наад зах нь 10 хүнтэй холбоо тогтооно (долоо хоногт наад зах нь 50).

(Эдгээрийн зарим нь таны урьд өмнө холбоо барьсан хүмүүс байх ёстой.)

Зорилгоо дугуйл: 50 55 60

Би боломжит ажил олгогч ба бусад хүнтэй өдөрт наад зах нь 2 нүүр тулсан уулзалт хийнэ (долоо хоногт наад зах нь 10).

Зорилгоо дугуйл: 10 12 14

Би өнөөдрийн “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

Миний гарын үсэг

Хамтрагчийн гарын үсэг

БИ ГАРГАЖ БУЙ АХИЦАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

Дадлага хий: Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх зайд “Тийм”, “Үгүй” гэж, эсвэл амлалтаа биелүүлсэн тохиолдлынхоо тоог бич.

Эх сурвалж: Наад зах нь өдөрт 15, долоо хоногт 75-ыг тодорхойлсон (Тоог бич)	Холбоо тогтоох: Наад зах нь өдөрт 10, долоо хоногт 50 хүнтэй холбоо тогтоосон (Тоог бич)	Нүүр тулсан уулзалт: Наад зах нь өдөрт 2, долоо хоногт 10 хүнтэй уулзсан (Тоог бич)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

Унш: Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” дээрх сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. (“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 13-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа srsfeedback@ldschurch.org хаягаар илгээнэ үү.

Эх сурвалж

ӨДӨР БҮР АЖИЛ ХАЙХ НЬ: АЛБАГИЙН ТҮҮХ

Дараах өгүүллийг унших хэн нэгнийг сонго.

Би ажилгүйгээсээ болж цөхрөн, энэ нь намайг хүнд байдалд оруулсан юм. Тэгэхэд Тэнгэрлэг Эцэг минь л надад хэрэгцээгээ ишийдвэрлэхэд минь тусалсан. Тэрээр хэн нэгнийг ирүүлж, намайг бие даах чадвар хөгжүүлэх төвөөр айлчлахыг урихад хүргэсэн юм. Тэнд тэд ажил эрчимтэй хайх гэсэн нэртэй ажил хайх хөтөлбөрийг эхлүүлж байв. Энэ бол хэрхэн хурдан ажил олохыг заадаг стратеги. Ямар гайхалтай адислал гээч!

Энэ аргаар дамжуулан би засгийн газрын чухал байгууллагад удаан хугацаагаар ажилд ороход туслах эх сурвалжийг олж билээ. Би харилцаа холбооны хэлтсийг хариуцахаар томилогдсон. Энэ нь миний залбиралд Бурхан хариулснаар боломжтой болсон гэдэгт би огт эргэлзэхгүй байна.

81-р хуудас руу буцаж оч

ӨДӨР ТУТАМ АЖИЛ ХАЙХ НЬ: ЭХ СУРВАЛЖ

Дараахыг ээлжилж уншина уу.

Бид судруудаар дамжуулан, “хүмүүс сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж, мөн чөлөөт хүсэл зоригоороо олон зүйлийг хийж, Учир нь хүч тэдэнд буй, үүгээр тэд өөрсдийнхөө төлөө сонгогчид юм” гэдгийг мэдэж авдаг. Энэ зарлиг нь “Мөн хүмүүс сайныг үйлдэхийн хэрээр тэд яавч шагналаа алдах учиргүй” гэсэн нэгэн амлалтыг дагуулдаг (С ба Г 58:27–28).

Үр дүнтэй ажил хайдаг хүмүүс “хүч тэдэнд буй” бөгөөд тэд “санаа сэтгэлээ бүрэн зориулах” үед Бурхан тэдэнд тусална гэдгийг ойлгодог. Тухайлбал, бид гурван хэсгээс бүрдсэн ажил хайх шалгарсан нэг стратегийг ярилцах болно. Үүнийг ажил эрчимтэй хайх гэж нэрлэдэг.

Нэгдүгээрт, ажил амжилттай хайдаг хүмүүс өдөр бүр 15 шинэ эх сурвалж тодорхойлдог. Хоёрдугаарт, тэд өдөр бүр 10 хүнтэй холбоо барьдаг. Гуравдугаарт, тэд өдөр бүр наад зах нь 2 нүүр тулсан уулзалт эсвэл ярилцлага хийдэг.

Ажил эрчимтэй хайхад эхэндээ маш хэцүү санагдаж болно. Гэхдээ бид хэсэг бүрийг ярилцсанаар энэ нь боломжтой бөгөөд

амжилттай гэдгийг та нар харах болно.

Эх сурвалжийг судалж эхэлье. Эх сурвалж гэж юу вэ? Эх сурвалж гэдэг нь хүн, газар, эсвэл ажил хайгчийг боломж руу хөтөлж чадах ямар нэг зүйл юм.

Хүмүүс гэдэгт найзууд ба гэр бүл, Сүмийн гишүүд ба удирдагч, ажил олгогчид эсвэл хамт ажиллагч, сургуулийн багш болон ажил мэргэжлийн зөвлөх, дэлгүүрт буй хүмүүс гээд хэрэгцээтэй ажлын мэдээлэл, эх сурвалжаар таныг хангаж чадах хүмүүс юм.

Газар гэдэгт худалдааны танхим, орон нутгийн ажил эрхлэлтийн албад болон иргэний эсвэл мэргэжлийн холбоонууд орно. Эдгээр нь бүгд таныг хэрэгтэй мэдээллээр хангадаг.

Таны ажил хайх явцыг сайжруулах зүйл нь бизнес ба утасны лавлах, компанийн вэб хуудас, интернэт, худалдааны мэдээ, сэтгүүл, сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг багтаадаг.

Өдөр бүр эдгээрээс наад зах нь 15 зүйлийг жагсаан бич.

82-р хуудас руу буцаж оч

ӨДӨР ТУТАМ АЖИЛ ХАЙХ НЬ: ТАНИЛУУД

Дараахыг ээлжилж уншина уу.

Одоо хэрхэн холбоо тогтоох талаар ярилцъя. Холбоо тогтоох гэдэг нь товч намтраа явуулах эсвэл өргөдөл бөглөх төдий зүйл биш юм. Та тодорхойлсон бүх эх сурвалжаасаа ажил эрхлэлттэй холбоотой 10 хүнийг тодорхойл.

Танилын хэлхээ холбоо гэдэг нь ажилд өргөдөл бөглөх, хэн нэгэнд товч намтраа эсвэл талархлын зурвас илгээх, мөн найз, гэр бүл, Сүмийн гишүүдэд ажил хайж байгаагаа хэлэх эсвэл мессеж, э-мэйл бичих гэх мэт ажил эрхлэлттэй холбоотойгоор

таны хүмүүстэй үүсгэсэн харилцаа холбоо юм. Та түүнчлэн өөр бусад сүлжээний танилууд ба боломжит ажил олгогчтой уулзсан байж болно. Хүмүүстэй харилцах өөр өөр боломжуудыг эрж хай, мөн ажил хайж байгаа гэдгээ тэдэнд хэл. Ихэнх хүн таныг таньдаг хүмүүстэйгээ дуртайяа танилцуулах болно. Эдгээр харилцаа холбоо нь ярилцлага руу, ярилцлага нь ажил руу хөтлөх болно!

82-р хуудас руу буцаж оч

ӨДӨР ТУТАМ АЖИЛ ХАЙХ НЬ: УУЛЗАЛТУУД

Дараахыг ээлжилж уншина уу.

Эцэст нь хэлэхэд, үр дүнтэй ажил хайдаг хүмүүс өдөр бүр наад зах нь хоёр хүнтэй нүүр тулж уулзахын үнэ цэнийг ойлгосон байдаг. Энэ нь өдөр бүр таны хийх хамгийн чухал зүйл байж болох юм. Яагаад? Нүүр тулсан уулзалт, ярилцлагууд нь илүү сайн харилцаа, ойлголтыг бий болгодог. Хүмүүс ихэвчлэн биеийн хэлэмж ба нүүрний хувирлаараа “ярьдаг.” Эдгээр үгийн бус харилцааг э-мэйлээр юм уу утсаар илэрхийлэх боломжгүй юм. Биечлэн уулзах үед хүмүүс таныг ямар гайхалтай болохыг харж мөн мэдэрч чадна!

Түүнчлэн нүүр тулсан уулзалтууд нь ажиллаж магадгүй орчноо харах боломжийг танд олгодог. Та хүмүүсийн хэрхэн харилцаж байгааг, хэр нөхөрсөг эсвэл аз жаргалтай байгааг болон тухайн байгууллагын амжилт, ямар хэрэгцээ эсвэл боломжууд байгааг мөн тэдгээр хэрэгцээг та хэрхэн хангаж чадах зэрэг зүйлсийг анзаарч чадна. Ямар ч төрлийн ярилцлага сайхан боломж байдаг!

Нүүр тулсан уулзалт бүрийг боломжит ажил олгогчтой хийх шаардлагагүй. Та мөн найзууд, гэр бүл, мөн найзын найз, нарийн бичиг, багш, зөвлөхүүдтэй, эсвэл таны хийхийг хүсэж буй ажлыг хийдэг хүмүүстэй уулзаж болно. Зүгээр л хүмүүстэй уулз! Тэдэнд “Би 30 секундэд” танилцуулгаа хэлж, мөн төгсгөлийн асуултаа ашиглаад ажлын боломж ба уулзах өөр хүмүүсийг асуу. Үүнийг үргэлжлүүлэн хийж бай. Эрхэмлэдэг зүйлүүдээ ойлгуулж, тусламж, зөвлөгөө хүсэж байгаарай. Агуу зүйлүүд тохиолдох болно!

Үүнийг ажил эрчимтэй хайх гэж нэрлэдэг! Та өдөр бүр 15 эх сурвалжийг тодорхойлж, 10 хүнтэй холбоо тогтоовол нүүр тулсан 2 ярилцлага хийх нь амархан байх болно. Энэ нь ажил хайх явцыг тань хэрхэн хурдасгахыг хараад та гайхах болно. Үүнийг агуу итгэлээр хий, ингэснээр таны төсөөлж ч байгаагүй үүд хаалга нээгдэх болно.

82-р хуудас руу буцаж оч

ӨДӨР ТУТАМ АЖИЛ ХАЙХ НЬ: БҮГДИЙГ ХАМТАД НЬ АШИГЛАХ НЬ

Дараахыг ээлжилж уншина уу.

Ажил эрчимтэй хайхын гурван хэсэг нь салангид үйл ажиллагаанууд биш юм. Та хийж үзээд, эх сурвалж хаа сайгүй байгааг харах болно. Өдөр бүрийг жагсаалтдаа ямар нэгэн зүйл нэмж бичих замаар эхлүүл. Та үүнийг хийснээрээ хүмүүстэй холбоо барих арга замуудыг бодож, мөн холбоо тогтоосноор аяндаа уулзалт руу хөтөлдөг.

Бие даах чадвар хөгжүүлэх энэхүү бүлэг бол эх сурвалж, танил тал, уулзалтуудын гайхалтай эх сурвалж юм. Сүмийн гишүүн, хөршүүд эсвэл хамтран ажиллагчид ч гэсэн үүнтэй адил. Холбоо тогтоох бүрдээ эх сурвалжуудаа нэмж бичиж

бай. Нүүр тулсан уулзалт хийх үедээ өөр хүний холбоо барих мэдээллийг асуу. Уулзсан хүн бүртэйгээ ярилцлаганд дахин оролцохыг хүс.

“Би 30 секундэд” танилцуулгаа ашигла. Ажил эрчимтэй хайх нь боломжтой зүйл бөгөөд хийгээд эхлэхэд л сонирхолтой санагдах болно. Тиймээс зүгээр битгий суу. Хүн бүртэй ярилц. Ариун Сүнсний удирдамжийг байнга эрэлхийлж, зохистой амьдар. Сайн тэмдэглэл хөтлөөд, үүнийхээ дагуу үйлд. Таныг үйлдэх үед Их Эзэн замаа олоход тань тусална.

82-р хуудас руу буцаж оч

ХОЛБОО БАРИХ ХҮМҮҮСИЙГ БҮРТГЭХ МАЯГТ

ХОЛБОО БАРИХ

Хувь хүн эсвэл байгууллага: _____

Утас: _____ Хаяг: _____

Э-мэйл хаяг: _____ Намайг танилцуулсан хүн: _____

Би энэ хүнтэй холбоо тогтоосон Тийм Үгүй Огноо: _____

ЯРИЛЦСАН АСУУДАЛ:

1. _____

2. _____

3. _____

ДАРАА ХИЙХ ЗҮЙЛС:

1. _____ Дуусгасан байх (огноо): _____

2. _____ Дуусгасан байх (огноо): _____

3. _____ Дуусгасан байх (огноо): _____

ШИНЭ ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ:

1. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

2. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

ХОЛБОО БАРИХ

Хувь хүн эсвэл байгууллага: _____

Утас: _____ Хаяг: _____

Э-мэйл хаяг: _____ Намайг танилцуулсан хүн: _____

Би энэ хүнтэй холбоо тогтоосон Тийм Үгүй Огноо: _____

ЯРИЛЦСАН АСУУДАЛ:

1. _____

2. _____

3. _____

ДАРАА ХИЙХ ЗҮЙЛС:

1. _____ Дуусгасан байх (огноо): _____

2. _____ Дуусгасан байх (огноо): _____

3. _____ Дуусгасан байх (огноо): _____

ШИНЭ ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ:

1. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____

2. Нэр: _____ Утас: _____ Факс: _____

Э-мэйл хаяг: _____ Хаяг: _____



6

*Би ажлаа хэрхэн сайн
гүйцэтгэж, үргэлжлүүлэн
амжилт гаргах вэ?*

Ажил хайх нь

ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

Цугларалт хийх өдөр:

- Бүлгийн гишүүд рүү мессеж илгээ, эсвэл утсаар ярь. Тэднийг цугларалт эхлэхээс 10 минутын өмнө ирж, амлалтаа хэрхэн биелүүлсэн талаар тайлагнахад урь.
- Цугларалтын үеэр ашиглах материалуудыг бэлд.

Цугларалт эхлэхээс 30 минутын өмнө:

- Бүх хүнийг нэг нэгэнтэй нь ойрхон суулгахын тулд ширээ тойруулан сандлуудаа тавь.
- Энэ амлалтын хүснэгтийг самбар дээр зур.

Бүлгийн гишүүний нэр	Эх сурвалж: Наад зах нь өдөрт 15, долоо хоногт 75-ыг тодорхойлсон (Тоог бич)	Холбоо тогтоох: Наад зах нь өдөрт 10, долоо хоногт 50 хүнтэй холбоо тогтоосон (Тоог бич)	Нүүр тулсан уулзалт: Наад зах нь өдөрт 2, долоо хоногт 10 хүнтэй уулзсан (Тоог бич)	“Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгалам-жиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамт-рагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)
Глория	80	53	11	Т	Т	Т

Цугларалт эхлэхээс 10 минутын өмнө:

- Хүмүүсийг орж ирэхэд дотно хүлээж авч утг.
- Бүлгийн гишүүдийг орж ирэхэд, тэднээс самбар дээрх амлалтын хүснэгтийг бөглөхийг хүс.
- Цаг бүртгэгч томил.

Цугларалт эхлэх үед:

- Хүмүүсээс гар утас болон бусад хэрэгслээ унтраахыг хүс.
- Нээлтийн залбирлаар эхэл (хүсвэл дуулал дуулж болно).
- Хүмүүсийг ярилцаж байх хооронд, хоцорч ирсэн хүмүүсээс гар утсаа унтрааж, амлалтын хүснэгтээ бөглөхийг нам дуугаар хүс.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимол дээр ажиллахад 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.
- “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын 6-р зарчмыг үзэж дуусга. Дараа нь энэ дасгалын номны дараагийн хуудаснаас үргэлжлүүлэн унш.



ТАЙЛАГНА

БИ АМЛАЛТАА БИЕЛҮҮЛСЭН ҮҮ?

Цаг: Тайлагна хэсэгт 20 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Амлалтаа тайлагнацгаая. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлсэн хүмүүс босно уу. (Алга таш.)

Унш: Одоо бүгдээрээ бос. Бүгдээрээ бүлгийнхээ уриаг хамт уншицгаая.

“Мөн өөрийн гэгээнтнүүдийг хангах нь миний зорилго болой, учир нь бүх зүйл минийх бөлгөө.”

Сургаал ба Гэрээ 104:15

Бид Их Эзэнд итгэх итгэлтэйгээр бие даахын тулд хамт ажиллаж байна.

Унш: Сууцгаая.

Ярилц: Та нар эх сурвалжийг тодорхойлж, хүмүүстэй холбоо тогтоон, мөн нүүр тулсан уулзалт хийж байх явцдаа юу сурч мэдсэн бэ?



СУРАЛЦ

БИ ХЭРХЭН АЖИЛДАА ОНЦГОЙ САЙН БАЙХ ВЭ?

Цаг: Суралц хэсэгт 60 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Унш: Бид сайн ажилд орсныхоо дараа энэ ажлаа хадгалж, онцгой сайн ажиллах хэрэгтэй. Бид чадах хэрээрээ хамгийн сайн ажилтан байх хэрэгтэй.

Унш: ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН АСУУЛТ—Би хэрхэн ажилдаа онцгой сайн байж, амжилттай хэвээр байх вэ?

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ХИЙХ ЗҮЙЛ—Би (1) ажилдаа онцгой сайн байж, (2) чадвараа ажил олгогчдоо нотлон харуулж, (3) ажил мэргэжлийн замналаа төлөвлөнө.

Үз: “Энэ миний асуудал биш” (Видео бичлэг байхгүй бол 108-р хуудсыг унш.)

Ярилц: Иосеф дарга яагаад Глория, Энтони хоёроос өөр өөрсдийнхөө асуудлыг шийдвэрлэхийг хүссэн бэ?

Үз: “Энэ миний асуудал биш” (Видео бичлэг байхгүй бол 109-р хуудсыг унш.)

Ярилц: Глория, Энтони хоёр хариуцлага хүлээснээрээ ажил олгогчийнхоо хувьд илүү үнэ цэнэтэй болсон. Яагаад?

Унш: Бид ажил хайх үедээ сурч мэдсэн арга хэрэгслүүдээ үргэлжлүүлэн ашиглаж, ажилдаа амжилт гаргах болно:

1. Хүмүүстэй холбоо тогтоож мөн сүлжээгээ өргөжүүлэх
2. Бусадтай ойлгомжтой байдлаар харилцаж, гадаад төрх ба харьцаагаа сайн байлгах
3. Шаргуу ажиллаж, ажил олгогчдоо үнэ цэнээ нотлон харуулах

БИ ХЭРХЭН АЖИЛДАА ЭЗЭН БОЛЖ МӨН АЖИЛ ОЛГОГЧДОО АМЖИЛТ ГАРГАХАД НЬ ТУСЛАХ ВЭ?

Унш: Ажил олгогчид зарим ажилтанг бусдаас илүү үнэлдэг. Үнэ цэнэтэй ажилтнууд компанид үргүй зардал болох бус харин илүү их ашиг авчирч, бүтээмжийг нэмэгдүүлдэг.

Ярилц: Ажил олгогчдоо туслах нь танд хэрхэн тус болох вэ?

Дадлага хий: Та өөрийгөө компанийн эзэн Иосеф гэж төсөөлөөд энэ гурван ажилтны талаар бодоод үз. Та ажилтан бүрд зориулж цалин, тоног төхөөрөмж ба бусад зүйлийн зардал гаргадаг. Ажилтан бүр бүтээгдэхүүн хийж, борлуулан эсвэл харилцагчдад үйлчилж мөнгө олдог.

БЕНЖАМИН



Олдог мөнгө: 50000
Компаниас
гарах зардал: 53000

Ашиг/Алдагдал: **-3000**

ГЛОРИЯ



Олдог мөнгө: 26000
Компаниас
гарах зардал: 25000

Ашиг/Алдагдал: **1000**

АНЖЕЛА



Олдог мөнгө: 45000
Компаниас
гарах зардал: 25000

Ашиг/Алдагдал: **20000**

Хажуудаа сууж буй хүнтэй ярилцахын тулд сандлаа ойртуул. Одоо хамтдаа эдгээр асуултанд хариул:

1. Хэн нь хамгийн үнэ цэнэтэй ажилтан бэ?
2. Хэн нь хамгийн бага үнэ цэнэтэй вэ?
3. Хэрэв та хэн нэгэнд урамшуулал болгон 2000-ыг өгөх гэж байсан бол хэнд өгөх байсан бэ?
4. Танай хамгийн бага үнэ цэнэтэй ажилтан сайжрахгүй бол та түүнийг халах уу?
5. Хэрэв өөр нэг компани танай хамгийн шилдэг ажилтанг авахыг оролдвол та түүнийг үлдээхийн тулд цалинг нь нэмэх байсан уу?

Хариултуудаа бүлгийн бүх гишүүнтэй ярилц.

Ярилц: Та нар бүлгээрээ хэрхэн илүү үнэ цэнэтэй ажилтан болж чадах талаар ярилц.

Дадлага хий: Хажуудаа сууж буй хүнтэй ярилцахын тулд сандлаа ойртуул. Асуулт бүрийн талаар ярилц мөн санаануудаа бич. Одоо хийж буй эсвэл хийхийг хүсэж буй ажилдаа та дараах зүйлсийг хэрхэн хийж чадах вэ?

1. Бизнестээ шинэ харилцагчдыг нэмэх

2. Одоогийн харилцагчдыг илүү сэтгэл ханамжтай мөн үнэнч болгох

3. Одоогийн харилцагчдаар илүү худалдан авалт хийлгэх

4. Бүтээгдэхүүний үнэ цэнэ ба үнийг нэмэгдүүлэх

5. Төлбөрөө илүү хурдан хийхэд эсвэл урьдчилж төлөхөд нь харилцагчдад туслах

6. Өөр арга замаар орлогоо нэмэгдүүлэхэд нь компанид туслах

БИ ХЭРХЭН АЖИЛДАА ЭЗЭН БОЛЖ, АЖИЛ ОЛГОГЧДОО ЗАРДЛАА БУУРУУЛАХАД НЬ ТУСАЛЖ ЧАДАХ ВЭ?

Унш: Бид үнэ цэнэтэй ажилтнуудын хувьд, зардал бууруулах арга замуудыг олох болно.

Ярилц: Зардал бууруулахад та хэрхэн тусалж чадах вэ?

Унш: Хоёр дахь видео бичлэг дээр тоног төхөөрөмжийг засвар үйлчилгээ хийлгэх хуваарьт оруулах сайхан санаа Энтонид төржээ. Тэр ажил олгогчдоо мөнгө хэмнэхэд нь туслах талаар суралцаж байлаа. Энэ хүснэгт ялгааг харуулдаг. Энтонигийн санаа таван жилийн хугацаанд 14500-г хэмнэхэд ажил олгогчид туслах болно. Энэ бол маш их хэмжээний мөнгө. Энтони үүнийг даргадаа үзүүлэх үед ажил олгогч Энтонигийн үнэ цэнийг сайн ойлгох болно.

	ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙГЭЭГҮЙ ҮЕД ГАРАХ ЗАРДАЛ		ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙСНЭЭР ГАРАХ ЗАРДАЛ		
	Засах	Солих	Засвар үйлчилгээ	Засах	Солих
Эхний жил	2000		100	0	0
2 дахь жил	2000		100	500	0
3 дахь жил		10000	100	0	0
4 дэх жил			100	500	0
5 дахь жил	2000		100	0	0
Нийт зардал	16000		1500		

- Дадлага хий:** Хажуудаа сууж буй хүнтэй ярилцахын тулд сандлаа ойртуул. Ээлжлэн хий. Та хэдэн хариулт олж чадахаа үзнэ үү.
1. Нэг нэгэндээ одоо хийж буй эсвэл хийхийг хүсэж буй ажлаа дүрслэн хэл.
 2. Нэг нэгнийхээ ажил дээр дараах зүйлүүдийг хийх бүх санааг бодож ол:
 - Цаг хэмнэ
 - Үйл явцыг сайжруул
 - Төхөөрөмж эсвэл бүтээгдэхүүнийг илүү сайн арчилж торд
 - Алдааг багасга
 3. Санаануудаа бичиж аваад, дараагийн цугларалтаас өмнө эдгээрийг ажил дээрээ хэрэгжүүлэхийг хичээ. Хэрэв та ажилд орж амжаагүй бол ажилд орсныхоо дараа санаануудаа хэрэгжүүлэх арга замыг бодож үз.
-
-

БИ ХЭРХЭН АЖИЛ МЭРГЭЖЛИЙНХЭЭ ТӨЛӨӨ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ВЭ?

Унш: Баруун гар талд байгаа судрыг хамтдаа унш.

Ярилц: Таны одоо хийж буй ажил (эсвэл хийхийг хүсэж буй ажил) бие даах чадвартай болоход тань туслах уу? Их Эзэн та нарт илүү сайн ажил олоход бэлтгэхэд тусална гэдэгт та итгэдэг үү? Тэр үүнийг хэрхэн хийх вэ?

Үз: “Тэр орд харш барьж байна” (Видео бичлэг байхгүй бол 110-р хуудсыг унш.)

Ярилц: Та нар энэ видео бичлэгээс юу сурсан бэ? Та нар юу мэдэрсэн бэ?

Дадлага хий: Бүлгийн өөр нэг хүнтэй ярилцахын тулд сандлаа ойртуул.

1. Одоо хийж буй эсвэл хийхийг хүсэж буй ажлаа дүрслэн хэл.
2. Хоёроос дөрвөн жилийн дараа ямар ажилтай байхыг хүсэж байгаагаа дүрсэл. Энэ нь нэг ажил уу эсвэл өөр үү?
3. Ариун сүм рүү явах, номлолд үйлчлэх эсвэл бусдад туслах хангалттай мөнгөтэй байвал ямар байх талаар ярилц.
4. Ярилцсан зүйлүүдээ эдгээр хүснэгтэд бич.

Суралцагчид “Миний зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно” гэсэн хэсгийг олсон эсэхийг магадал.

2 НИФАЙ 4:4

ТАНЫ ОДОО БАЙГАА НӨХЦӨЛ БАЙДАЛ

ТАНЫ ЗОРИЛГО

САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА: АМЖИЛТ ГАРГАХАД ТУСЛАХ ЗӨВЛӨГЧ ХЭРХЭН ОЛОХ ВЭ

(ҮҮНИЙГ ЦУГЛАРАЛТЫН ҮЕЭР ХИЙХГҮЙ.)

Хэрэв та нар хүсвэл энэ үйл ажиллагааг дараагийн цугларалтаас өмнө хийж болно:

Зөвлөгч нь ажлын талбар дахь бичигдээгүй дүрмийг болон юу хүсэн хүлээж байдгийг мэдэхэд танд тусалж чадна. 111-р хуудсыг судал.

НАМАЙГ ЗОРИЛГОДОО ХҮРЭХЭД ТУСЛАХ ЯМАР АРГА ХЭРЭГСЭЛ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Унш: Бид зорилгуудынхаа талаар ойлголттой боллоо. Зорилгодоо хэрхэн хүрэх вэ? Баруун гар талд байгаа судрыг уншицгаая.

Ярилц: Христ та нарыг материаллаг зүйлийн хувьд адислах чадвартай юу? Энэ нь ажил олоход та нарт туслах, ажилдаа үлдэх, ажилдаа амжилт гаргах зэргийг багтаадаг уу?

Унш: Их Эзэн ажлаар маань дамжуулан бидэнд туршлага өгч, ур чадвар ба мэдлэгтэй болоход тусална. Тэр түүнчлэн суралцах ба бэлтгэхээр дамжуулан мэдлэг олж авахыг биднээс хүсэн хүлээдэг. Тодорхой эрдмийн зэрэгтэй эсвэл гэрчилгээтэй хүмүүс олон ажил хийх боломжтой байдаг. Боловсрол нь ажилдаа амжилт гаргах мөн ажил олгогчдодоо илүү үнэ цэнэтэй болох боломжийг бидэнд олгодог.

Дадлага хий: Ирээдүйд хийхийг хүсэж буй ажилдаа хэрэгтэй ур чадвар, мэдлэгийг жагсааж бич. Эдгээрийг олж авах арга замуудыг жагсааж бич. Зорилгодоо хүрэхийн тулд таны хийх дараа дараагийн алхам юу вэ? (Жишээ үзүүлэв.)

“Учир нь аврах чадал бүхий түүний гавьяанд та нар бүрэн дүүрнээр даатган, түүнд хэлбэрлэлтгүй итгэлтэйгээр Христийн үгсээр бус аваас өдий зэрэгт хүрээгүй болой.”

2 Нифай 31:19

ТАНЫ ХҮСЭЖ БУЙ АЛБАН ТУШААЛ	ТАНД ХЭРЭГТЭЙ УР ЧАДВАР БА МЭДЛЭГ	УР ЧАДВАР БА МЭДЛЭГ ОЛЖ АВАХ АРГА ЗАМ	ДАРААГИЙН АЛХАМ
Барилгын менежер	Инженерийн ур чадвар Төлөвлөх ур чадвар Асуудлыг шийдвэрлэх ур чадвар Харилцааны ур чадвар	Мэргэжлийн эсвэл техникийн сургуулийн курсууд эсвэл коллежийн инженерийн эрдмийн зэрэг	Дараагийн алхмаа төлөвлөхийн тулд “Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь” бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт нэгдэх



ТУНГААН БОД

БИ АХИЦ ГАРГАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Цаг: Тунгаан бод хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Баруун гар талд байгаа судрыг унш, эсвэл өөр судар хуваалцахыг бод. Суралцаж байгаа зүйлийнхээ талаар чимээгүй тунгаан бод. Төрсөн сэтгэгдлээ доор бич.

Ярилц: Санал бодлоо хуваалцах хүн байна уу?

“Их Эзэний үгсийг анхааралтай сонс. Бүү эргэлз, харин итгэлтэй бай.”

МОРМОН 9:27



АМЛАЛТ ӨГ

БИ ХЭРХЭН ӨДӨР БҮР АХИЦ ГАРГАХ ВЭ?

Цаг: Амлалт өг хэсэгт 10 минут зарцуулахаар тооцож, цаг хэмжигчийг тааруул.

Дадлага хий: Хамтрагчаа сонго. Нэг нэгэнтэйгээ хэзээ, хэрхэн холбоо барихаа шийд.

Хамтрагчийн нэр

Холбоо барих мэдээлэл

Амлалтаа нэг нэгээр нь хамтрагчдаа чанга уншиж өг. Өгсөн бүхий л амлалтаа биелүүлнэ гэдгээ амла! Доор гарын үсгээ зур.

МИНИЙ АМЛАЛТУУД

Хэрэв би ажилд орж амжаагүй байвал үргэлжлүүлэн ажил эрчимтэй хайх болно.

Би ажилдаа эзэн нь байж, ажлаа сайжруулах болно.

Би өнөөдрийн “Миний суурь: зарчим, ур чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заана.

Би хадгаламжиндаа ганц хоёр төгрөг байсан ч нэмж хийнэ.

Би хамтрагчдаа тайлагнана.

Миний гарын үсэг

Хамтрагчийн гарын үсэг

БИ ГАРГАЖ БУЙ АХИЦАА ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

Дадлага хий: Дараагийн цугларалтын өмнө гаргаж буй ахицаа тэмдэглэхийн тулд энэ амлалтын хүснэгтийг ашигла. Доорх хүснэгтэд “Тийм” эсвэл “Үгүй” гэж бич.

Ажил эрчимтэй хайсан (Тийм/Үгүй)	Ажлаа сайжруулсан (Тийм/Үгүй)	“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын зарчмаар дадлага хийж, уг зарчмыг гэр бүлийнхэндээ заасан (Тийм/Үгүй)	Хадгаламжиндаа мөнгө нэмж хийсэн (Тийм/Үгүй)	Хамтрагчдаа тайлагнасан (Тийм/Үгүй)

Унш: Дараагийн цугларалтаар бид илүү бие дааж чадсан эсэхийг мэдэхийн тулд бие даасан байдлын үнэлгээг давтан хийнэ. Бид “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлоо авчрах хэрэгтэй.

Дараагийн долоо хоногт “Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” дээрх сэдвээр зохицуулагч хийх хүнийг сонго. (“Миний суурь: зарчим, үр чадвар, дадал хэвшил” товхимлын сэдвээр хэрхэн зохицуулагч хийхээ мэдэхгүй байна уу? 13-р хуудсыг болон хавтасны нүүр хуудасны дотор талыг уншина уу).

Хэн нэгнээс хаалтын залбирал хийж өгөхийг хүс.

Санал хүсэлт

Санал, сэтгэгдэл, санаа бодол болон туршлагаа srsfeedback@ldschurch.org хаягаар илгээнэ үү.

Зохицуулагчийн анхааралд:

Дараагийн цугларалтад “Миний бие даах чадвартай болох арга зам” товхимлын таван хувийг илүү авч ир.

Үүнээс хойш хийх цугларалтууд өмнөх цугларалтуудаас зарим талаар өөр байх болно. Дараагийн цугларалт болохоос өмнө материалыг уншиж мөн асуултуудад хариулахад бэлэн бай.

Эх сурвалж

ЭНЭ МИНИЙ АСУУДАЛ БИШ

Дүрээ сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

ИОСЕФ (ДАРГА): Глория, чи гурван цаг хоцорлоо.

ГЛОРИЯ: “Уучлаарай, Иосеф. Би бага зэрэг унтах хэрэгтэй байсан юм. Өнгөрсөн шөнө хүү минь өвчтэй байсан болохоор бараг унтаж чадаагүй.

ИОСЕФ: Энэ миний асуудал биш.

ГЛОРИЯ: Тэгээд бас сэрүүлэг маань өнөө өглөө дуугарсангүй.

ИОСЕФ: Миний асуудал биш.

ГЛОРИЯ: Би гарах гэсээр байгаад эхний автобуснаас хоцорчихсон.

ИОСЕФ: Энэ чинь бас л миний асуудал биш.

ГЛОРИЯ: Би автобусны буудал дээр ирээд, зардлын мөнгөгүйгээ мэдсэн.

ИОСЕФ: Миний асуудал биш шүү дээ.

ГЛОРИЯ: Би гэртээ буцаж очоод мөнгө авах хэрэгтэй байсан учраас дараагийн автобуснаас ч бас хоцорсон.

ЭНТОНИ: Яриаг чинь тасалдуулсанд уучлаарай. Төхөөрөмж эвдэрчихээд, шингэн зүйл гоождо байна.

ИОСЕФ: Ямар төхөөрөмж вэ?

ЭНТОНИ: Ямар нэртэйг нь би мэдэхгүй байна. Тавиуруудын хажууд, буланд байгаа нь. Томас өнөөдөр ирсэнгүй. Тэр ер нь төхөөрөмжийг ажиллуулдаг.

ИОСЕФ: Энэ миний асуудал биш.

ЭНТОНИ: Би төхөөрөмжийг ашиглаж эхэлтэл гацчихлаа.

ИОСЕФ: Ямар хэцүү юм бэ. Энэ чинь миний асуудал биш.

ЭНТОНИ: Төхөөрөмжний гарын авлага гэж байгаа байх. Гэхдээ би хаана байгааг нь мэдэхгүй байна.

ИОСЕФ: Одоо болно. Та хоёр одоо яриагаа боль! Энтони, Глория, та нар асуудлуудаа өөрсдөө шийдвэрлэ!

98-р хуудас руу буцаж оч

ЭНЭ БОЛ НАДАД ХАМААТАЙ АСУУДАЛ.

Дүрээ сонгоод, дараах үйл явдлыг жүжигчлэн үзүүл.

ИОСЕФ: Энтони, чи Томас руу залгаад, хэзээ эргэж ирэхийг нь асуух уу? Бидэнд төхөөрөмжний шингэн хэрэгтэй байна.

ЭНТОНИ: Бидэнд шингэн хэрэг болно гэдгийг би мэдсэн. Би өөрөө шингэн худалдаж аваад дүүргэчихлээ.

ИОСЕФ: Юу? Чи Томасыг хүлээгээгүй юм уу? Би чамаар тэр төхөөрөмжийг дахин эвдүүлмээргүй л байна шүү.

ЭНТОНИ: Би одоо төхөөрөмжийг сайн мэддэг болсон. Би гарын авлагыг олж, гэртээ судлаад, эргэж ирэн төхөөрөмжийг зассан. Одоо Томас гадуур харилцагчтай уулзаж байх хооронд би асуудлыг шийдэж чаддаг болсон.

ИОСЕФ: Сайн байна.

ЭНТОНИ: Би бас нэг зүйл хийсэн. Би гарч болзошгүй асуудлаас сэргийлэхийн тулд төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийх хуваарь гаргасан.

ИОСЕФ: Баярлалаа, Энтони. Энэ асуудлыг ингэж шийдвэрлэсэнд чинь талархаж байна.

ЭНТОНИ: Зүгээр дээ. Энэ надад хамаатай асуудал.

ИОСЕФ: [Дотроо бодов] Хөөх, Энтони сайн байна шүү. Тэр өнөөдөр өөрийгөө харуулж чадлаа.

ИОСЕФ: Хөөе, Глория. Чи ажилдаа яаж ирсэн бэ? Анжела утасдаад, автобусны жолооч нар жагсаал хийж байгаа учраас

ажилдаа ирж чадахгүй гэж хэлсэн. Би Бенжамин та хоёрыг бас ирэхгүй байх гэж бодож байлаа.

ГЛОРИЯ: Би автобусны жолооч нар жагсаал хийнэ гэдгийг мэдэж байсан болохоор хэд хоногийн өмнө Бенжаминтай яриад, жагсаал болбол түүний машинаар ирнэ гээд тохирсон байсан.

ИОСЕФ: Үүнийг урьдчилж бодсон чинь сайн байна.

ГЛОРИЯ: Би бас шатахуун түгээх станцууд ачаалал ихтэй болно гэж бодоод Бенжаминд мөнгө өгөөд, жагсаал хийх шийдвэр гарахаас өмнө тулиний саваа дүүргэж авахыг хүссэн юм.

ИОСЕФ: Чамд хангалттай мөнгө байсан юм уу?

ГЛОРИЯ: Тийм ээ, би автобусанд зарцуулах мөнгөө хадгалж байсан болохоор шатахуун авахад зарцуулсан. Бенжамин бид хоёр Анжелаг замаараа аваад ирсэн.

ИОСЕФ: Глория, эдгээр зүйлийг урьдчилж бодсонд чинь баярлалаа. Өнөөдөр та гурвуулаа үйлчлүүлэгчдэд маш их хэрэгтэй байна.

ГЛОРИЯ: Зүгээр дээ, Иосеф. Энэ бол надад хамаатай асуудал.

ИОСЕФ: [Дотроо бодов] Би түүнийг халах гэж байсан бил үү? Өнөөдөр тэрээр гурван ажилтны хийх зүйлийг хийлээ.

98-р хуудас руу буцаж оч

ТЭР ОРД ХАРШ БАРЬЖ БАЙНА

Дараах үйл явдлыг унших хэн нэгнийг сонго.

“Өөрийгөө амьд байшин гэж төсөөл. Бурхан энэ байшинг дахин барихаар иржээ. Эхлээд та Түүний юу хийж байгааг ойлгоно. Тэр ус зайлуулагчийг янзалж, дээврийг битүүлэн, ус алдалтыг зогсооно. Энэ засварууд хийгдэх ёстой байсан гэдгийг та мэдэж байгаа болохоор огтхон ч гайхахгүй. Гэвч Тэр удалгүй байшинг нүдэж эхлэхэд энэ нь аймшигтай өвдөх ба учир нь ойлгогдохгүй байлаа. Тэр юу хийх

гэж байгаа юм бол? Хариулт нь гэвэл, Тэр таны бодож байснаас нэлээд өөр байшин барьж байгаа юм. Шинэ жигүүр, нэмэлт давхар, өндөр цамхаг болон цэцэрлэг байгуулж байна. Та өөрийгөө ердийн л нэг жижигхэн байшин болно гэж бодож байсан боловч Тэр орд харш барьж байна” (С. Льюис, Mere Christianity [1960], 160).

103-р хуудас руу буцаж оч

НАМАЙГ АМЖИЛТАНД ХҮРЭХЭД ТУСЛАХ ЗӨВЛӨГЧИЙГ БИ ХЭРХЭН ОЛОХ ВЭ? (САНАЛ БОЛГОСОН ҮЙЛ АЖИЛЛАГАА)

Унш: Үнэ цэнэтэй ажилтан нь ажил олгогчийн дүрмийг болон түүний хүсэн хүлээж буй зүйлийг мэддэг. Гэсэн хэдий ч тэдгээр хүлээлтийг тайлбарласан “компанийн гарын авлага” байдаггүй. Байгууллага бүр өөр байдаг.

Дадлага хий: Ямар нэг байгууллагын бичигдээгүй дүрэм, тэдний хүсэн хүлээдэг зүйлийг хэрхэн олж мэдэх талаар бодож үз. Та түүнчлэн гэр бүлийн гишүүд, найзууд эсвэл бүлгийн гишүүдийн санаа бодлыг асууж болно.

Унш: Зарим хүлээлт ойлгомжтой байдаг. Заримыг нь ажигласнаар мэдэж болдог. Гэвч бусдыг нь мэдэхийн тулд та нарт зөвлөгч хэрэгтэй. Зөвлөгч гэдэг нь компанийн шаардлага, дүрмийг мэддэг, суралцахад тань туслахад бэлэн, итгэж болох хүн юм.

Дадлага хий: Дараагийн цугларалт болохоос өмнө ажил дээрээсээ нэг зөвлөгчийг сонгож аваад, түүнээс компанийн дүрэм, тэдний хүсэн хүлээдэг зүйлийг ойлгоход туслахыг хүс.

Эсвэл ирээдүйд ямархуу зөвлөгчтэй болохыг хүсэж байгаагаа дүрслэн хэл.



7

*Ажлын талаар яг
одоо надад тулгарч
буй хамгийн том
бэрхшээл юу вэ?*

Ажил хайх нь

ЗОХИЦУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

Цугларалт хийх өдөр:

ШИНЭ!

